

УЛС ТӨР

Ц.ЭЛБЭГДОРЖ: ЕРӨНХИЙ САЙДЫН АСУУДЛЫГ ӨНӨӨДӨР УИХ-ААР ХЭЛЭЛЦҮҮЛНЭ

II нүүрт

ЗАВСАРЛАГА

ТҮРҮҮ БӨХИЙГ ШИНЭ ЗАГВАРЫН ЛАНД 200 МАШИНААР ШАГНАНА

VIII нүүрт

УРАН БҮТЭЭЛЧ



Дугаарын **60** мөр
Хотол түмнээрээ сайхан наадаарай

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Н.ЛУНЦАГБОЛД

Э.ТУУЛ

Дэнж хотойлгон наадаг дэлхийд ганцхан монгол наадам эхлэхэд ердөө гуравхан хоног үлдээд байна. 11-ний өглөө монголчууд бид хэний хүү төрийн наадамд түрүүлж, хэний морь магнайдаа тоосгүй ирэхийг шинждэг, таадаг, таамгаа уралдуулдаг ард түмэн. Ай даа, монгол наадам ч дөхөж байна даа. Энэ жил нар хур тэгшрээд, дэлхий дэлэгнэж, сайхан зун болж байна. Өнгөрсөн жилийн өдийд хаа сайгүй гантай, хэцүүхэн байлаа. Тэр үеийг бодвол энэ жил ёстой л нэг зун болж байна. Нар, хур ээлжлээд, өвс ногоо ч сайн ургаж, наадмаа хий гэсэн шиг л байгаа. Ийм сайхан зунаар сайхан наадахгүй бол өөр яах билээ. Харин энэ жил наадмаар айхтар ширүүн бороо орох талаар цаг уурчид мэдээлээд байгаа. Мөн үе үе халуун нар шарах сураг байсан. Тэгэхээр наадамчин олон маань шүүхрээ сайн бэлтгэж явах хэрэгтэй болох нь. Борооноос ч, нарнаас ч сайтар хамгаалах томхон шиг шүүхрээ хэрэгтэй болов уу. Түүнээс бусдаар бол бүх юм сайхан болно.

Өнгөрсөн долоо хоногт УИХ-ын шинэ гишүүд ажилдаа орж, НИТХ-ын төлөөлөгчид хуралдаанаа хийж, АСЕМ-ын хурлууд үргэлжиллээ. АН, МАХН-ын дарга нар хамтран анхдугаар чуулганыг хуралдуулахыг эсэргүүцэж буйгаа мэдэгдэн, Ерөнхийлөгчтэй уулзахыг хүссэн ч хамгаалагч нар нэвтрүүлээгүй юм. Харин Ерөнхийлөгч анхдугаар чуулганыг даргалж, сонгуульд үнэмлэхүй ялалт байгуулсан МАН-ынхан УИХ-ын даргаараа намын дарга М.Энхболдыг дэмжиж, УИХ дахь АН, МАН-ын бүлэг байгуулагдсаныг УИХ-ын дарга М.Энхболд танилцуулснаар эрх үүрэг нь хэрэгжиж эхэллээ. УИХ дахь МАН-ын бүлгээс УИХ-ын гишүүн

Ц.Нямдоржийг УИХ-ын дэд даргад нэр дэвшүүлснийг гишүүдийн 97.1, УИХ дахь Ардчилсан намын бүлгээс УИХ-ын гишүүн Я.Санжмятавыг УИХ-ын дэд даргад нэр дэвшүүлснийг гишүүдийн 95.8 хувиар тус бүр дэмжин баталсан. Мөн Ерөнхий сайдад Ж.Эрдэнэбатыг "сойж", Бага хурлаараа хэлэлцэн дэмжиж, Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн. Тэгвэл НИТХ-ын төлөөлөгчид мөн хуралдаж, даргаараа Ц.Сандуйг сонгосон бол нийслэлийн Засаг даргаар УИХ-ын гишүүн асан Су.Батболдыг дэмжсэн юм. Ингээд өнгөрсөн долоо хоногт олны анхаарлыг татсан зарим хүний ярьсныг "Хэн юу хэлэв" булангаараа онцлон хүргэж байна.

Үргэлжлэл нь III нүүрт



С.НАРАН: ХУВЬ ТАВИЛАН НАМАЙГ ХӨТӨЛЖ ДУУЧИН БОЛГОСОН

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

МЭНДЧИЛГЭЭ

Туурга тусгаар, бүрэн эрхт Монгол Улсын маань эрх чөлөөт иргэд ээ

Хилийн чанадад ажиллаж, амьдарч байгаа элэг нэгт монголчууд аа

Манай сайхан оронд айлчилж байгаа болон ажиллаж амьдарч, улс түмний найрамдал, найрсаг харилцааны элч болж буй хүндэт зочид гийчид, гадаадын иргэд ээ

Тулгар төрийн 2225, Их Монгол Улс байгуулагдсаны 810, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний 105, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье.

Монгол хэмээх нэрийг ертөнцийн чихнээ дуурсгасан түүхт тэгш ойнууд давхцсан онцгой жил монгол түмний их баяр цэнгэл, наадам болж байна.

Наадам бол монгол түмний цог хийморийг сэргээж, итгэл сэтгэлийг бадраасан өнө эртнээс үүсэлтэй, гүн гүнзгий утга агуулгатай, ёслол төгөлдөр, үндэсний өвөрмөц ёс заншил, баяр цэнгэлийн манлай, туурга тусгаар, бүрэн эрхт Монгол Улсын эрх чөлөөт иргэдийн маань баяр бахархлын дээд билээ.

Ойрх түүхээс Ардын хувьсгалын 95 жилийн ойд онцгой ач холбогдол өгч байна.

Түүхэн энэ хугацаанд онож, алдан зүтгэсээр улс Монголоо дундад эртний хоцрогдсон байдлаас орчин цагийн соёл иргэншил, улмаар хүн төрөлхтний өнөөгийн жам ёсны гольдролд оруулсан гол гавьяа Монгол Ардын Намд зүй ёсоор оногдоно.

Ийм ч учраас наадмын өмнөхөн болсон Улсын Их Хурлын болон аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиар улс оронд нүүрлэсэн төрийн хямрал, эдийн засаг, нийгмийн хүндрэлээс гаргаж чадах боловсон хүчний чадавх, зохион байгуулалттай улс төрийн хүч бол Монгол Ардын Нам гэж монголын ард түмэн үзэж, өндөр итгэл найдвар хүлээлгэлээ.

Энэ агшинд 95 жилийн тэртээ төр, улсыг



байгуулахад хүн бүхний хүчин зүтгэл хэрэгтэй гэсэн их жанжин Д.Сүхбаатарын үг яг өнөөдөр хэлсэн юм шиг орой руу орж байна.

Улс орон маань өнөөгийн хүндрэлээс өргөс авах мэт амархан гарах боломжгүй нь хэн бүхэнд тодорхой.

Улс орноо өр зээлээс салгаж, эдийн засгаа сэргээхэд хүн бүхний хүчин зүтгэл чармайлт хэрэгтэй байна.

Манай нам, мөрийн хөтөлбөрийн үзэл санаагаа ард иргэд та бүхэнтэй хамтдаа, халуун зуур эе эвээ хичээж байж сая хэрэгжүүлэх болно.

Монгол Ардын Намын "Бид хамтдаа" хэмээх урианы учир холбогдол ч үүнд оршино.

Наадмын маргааш намар гэдэг. Зуны урин дулаан цагт тайвширч наазгайрахгүй намар, өвлийн бэлтгэлээ базааж эхлэх нь эн тэргүүний зорилт болж байна.

Баяр цэнгэл наадмаасаа бид бүтээж туурвихын эрч хүч авч, улс орныхоо хөгжлийн дахин сэргэлтийн шинэ гарааг эхлүүлнэ.

Хүчит бөхчүүдийн бяр нь их, мэх даацтай, Хуурнин шуугих аргамаг хүлгүүдийн шандас чанга,

Хүүхэд багачуудын гийнгоо хурц Хараа хол харваачдын нум нь хөвчтэй, сум нь онц мэргэн байх болтугай.

МИНИЙ АРД ТҮМЭН МОНГОЛ НААДАМДАА САЙХАН НААДААРАЙ.


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА,
МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА



Миезгомбын
ЭНХБОЛД

ХААН БАНК

2016 оны МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНКААР ШАЛГАРЛАА



САЙХАН НААДААРАЙ

www.khanbank.com

khanbank.com/facebook

khanbank.com/twitter

ХААН Банк



	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2010.00	2023.00	ФУНТ	2544.00	2660.00
ЕВРО	2198.00	2283.00	РУБЛЬ	29.30	33.80
ИЕН	19.58	20.38	ЮАНЬ	300.00	305.40

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2012.00	2025.00	ФУНТ	2552.00	2684.00
ЕВРО	2202.00	2290.00	РУБЛЬ	29.40	34.60
ИЕН	19.51	20.65	ЮАНЬ	302.30	306.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Олон улсын ажиглагчид сонгуульд "онц" дүн тавьжээ

УИХ-ын сонгуулийг энэ жил 430 гадны төлөөлөгч ажигласан. Тэд ажиглалтын урьдчилсан дүнгээ гаргасан байна. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлын 2016 оны сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй болсон бөгөөд сонгуулийн өдөр эмх журамтай болж өнгөрлөө. Сонгууль нь их өрсөлдөөнтэй эвлэлдэн нэгдэх эрхийг хүндэтгэсэн байдалд болов гэж олон улсын ажиглагчид үзжээ. Мөн санал тоолох төхөөрөмжийг шалган баталгаажуулах ажлыг СЕХ-ноос оролцогч талуудыг байлцуулан мэргэжлийн хэмжээнд хийснийг тэмдэглэхийн сацуу сонгуулийн системийг хожимдоо өөрчилснөөс үүдэн УИХ нэр дэвшигчдийн бүртгэлийн эцсийн хугацааг 57 хоног байсныг 25 хоног болгосон нь СЕХ-нд дарамт шахалт бий болгосон байна гэж тэд дүгнэсэн аж. Харин эцсийн тайлангаа хоёр сарын дараа гаргах бөгөөд түүнийг ирж танилцуулна гэдгээ Элчин сайд хатагтай Одри Гловер Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномдөрэнтийг уулзах үеэр мэдэгджээ. Элчин сайд, хатагтай Одри Гловер Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газрын Сонгуулийг ажиглах хорооны тэргүүн билээ. Тэрбээр тус байгууллага болон Европын парламентын ажиглагчдын багийг ахалж ажилласан юм байна.

Ц.ЭЛБЭГДОРЖ: ЕРӨНХИЙ САЙДЫН АСУУДЛЫГ ӨНӨӨДӨР УИХ-ААР ХЭЛЭЛЦҮҮЛНЭ

Ж.ОТГОН

МАН-ын бага хурлын шийдвэрийн дагуу ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшихээр болсон УИХ-ын гишүүн Ц.Элбэгдорж хүлээн авч уулзлаа. Уулзалтад МАН-ын дарга М.Энхболд мөн оролцсон юм. Уулзалтын үеэр Ц.Элбэгдорж “Үндсэн чиглэлийн яамдын сайд нь УИХ-ын гишүүн байж болно гэснийг хатуу баримталж, бусад нь давхардахгүйгээр дан сайдаар ажиллах нь гэж ойлголоо. Ард түмэн сонголт хийсэн учраас УИХ, Засгийн газрын ажлыг хурдан эхлүүлэх бодолтой байгаа. Мэргэжлийн Засгийн газар гэдгийн цаана мэргэжлийн гэдэг нэгдмэл ойлголттой байна. Өндөр шаардлагатай, ёс зүйтэй, хариуцсан ажлаа сайн хийдэг, тавигдсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чадвартай хүн сайд байх ёстой. Энэ парламент бүрэлдэхүүний хувьд онцлог байна, 65 гишүүнтэй байна гэдэг бол бодлого тодорхойлж байгаа. Тийм учраас Засгийн газарт хяналт байх ёстой. Ойр суудалтай байхад сөрөг хүчин хяналт тавьдаг байсан. Засгийн газарт маш яаралтай хийх ажил их бий. Гурав дахь нь азтай Ерөнхий сайд байх нь. АСЕМ-ын дээд төвшний уулзалт эхлээд байна. Гадаадын маш олон Ерөнхий сайд ирнэ. Хөрш орнуудын Ерөнхий сайд ирнэ. Тэр хүмүүстэй гар бариад, асуудлаа хэлээд, ажлаа эхэлнэ гэдэг сайн зүйл. Маш олон өндөр дээд төвшний зочид ирнэ. Дөрөвт, Засгийн газраас ажил хийлгэсэн байтал мөнгө өгөөгүй гэдэг гомдол гарсан. Хийсэн ажлынх нь мөнгө олгогдох ёстой. Иргэд, аж ахуйн нэгжүүд ажилтай байх нь



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

чухал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Болор бичлэг тавьсан байна, бид хүнлэг байх ёстой. 25 ажилтантай бол хөгжлийн бэрхшээлтэй хүнийг авч ажиллуул гэдэг хууль бий. Хүн рүүгээ хандсан байх ёстой. Үүнийг ажил хэрэг болгоход анхаарч ажиллаарай” гэв. Түүнчлэн Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгө жил бүр буураад байгаа. Тиймээс санхүүжилтийг нь өмнөх жилийнхээс бууруулахгүй баталж байх ёстой. Уг хөрөнгөөр орон нутгийн иргэд ажилтай болдог, орон нутагт үйлдвэртэй хөндөгдөж, “Эрдэнэт” үйлдвэртэй холбоотой маргаан гараад байгаа, энэ асуудлыг нээлттэй ярилцах байх гэж бодож байна. Монголынхоо тогоонд ороод ирсэн асуудлыг нээлттэй байдлаар хэлэлцэж шийдэх байх. Тэнд ажиллаж хамарсан, ач холбогдолтой хурал болж өнгөрсөн тухай зохион байгуулагч нар онцлоо. Ази, Европын түмний 11 дүгээр чуулганы үндэсний зохион

харж байгаа байх. Олон нийт хэвлэл мэдээлэл, сошиалаар дамжуулаад алхам бүрийг чинь харж байгаа. Та бүхэн шилэн дээгүүр алхаж байгаа юм шиг л ил харагдаж байгаа. Буруу гишгэсэн алхам бүр чинь ард түмний ой санамжид үлдэнэ. Эхний хоёр жилдээ буруу үйл ажиллагаа явуулаад намынхаа хүмүүс, хамтарч ажилладаг эргэн тойрны хүрээлэгчид, ах, дүүгээ ажилд оруулдаг. Төрийн алба дахь ийм ёс зүйгүй үйлдлийг зогсоомор байна. Төрийн албанд орсон хүн баяждаг, иддэг, уудаг гэсэн ойлголтыг авч хямаар байна. Ийм л байдал ажиглагдах юм бол ард түмний өгсөн итгэл борооны дараа татсан солонго шиг арилана. Эрх баригчид өөрчлөгдөж байна гэхдээ асуудал үлдсэн. Тэр асуудлыг шийдэх хүн бол Ерөнхий сайд. Ерөнхий сайдын асуудлыг маргаашдаа /өнөөдөр/ УИХ-руу оруулж батлуулна гэсэн

бодолтой байна. Энэ сарын 18-20-ны өдөр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүндээ байгуулахад онцгой анхаарах ёстой” гэж тодотгоод ажилд нь амжилт хүслээ.

Уулзалтын дараагаар Ж.Эрдэнэбатаас дараах асуултад хариулт авлаа.

-Та Ерөнхий сайд болоод хамгийн түрүүнд ажлаа юунаас эхэлнэ гэж бодож байгаа вэ?

-Засгийн газрын бүтцийн хувьд ярилцаж байгаад шийднэ. Хэрвээ би томилогдох юм бол эхний ээлжинд АСЕМ-ын уулзалтад цаг алдалгүй анхаарлаа хандуулах төлөвлөгөөтэй байна. Маш олон улсын төрийн тэргүүнүүд Монгол Улсад ирэх нь Монгол Тиймсэн гадаад хэргийн асуудал. Уулзалтаас цаг алдаж болохгүй. Би янз бүрийн хэрэгтэй, хэрэггүй уриа хэлэхгүй. Хийх

...Монголынхоо тогоонд ороод ирсэн асуудлыг нээлттэй байдлаар хэлэлцэж шийдэх байх. Тэнд ажиллаж байгаа нэг ч хүний эрх ашиг хохирох ёсгүй” гэдгийг онцлов. Мөн “Ер нь одоо та бүхэн харж байгаа байх. Олон нийт хэвлэл мэдээлэл, сошиалаар дамжуулаад алхам бүрийг чинь харж байгаа...

ёстой ажлаа л хийх ёстой. **-Төсвийн тодотгоолоо хэзээ хийх вэ?**

-Өнөөдрийн гаргаж байгаа тоо мэдээллүүд, бодит нөхцөл байдал ямар байгааг тодорхойлох хэрэгтэй. Сангийн сайдын албыг хүлээж авахад, нөхцөл байдал тоо мэдээлэл хоёр эерх байсан шүү дээ. Тиймээс эхний ээлжинд өнөөдрийн гаргаж байгаа тоо мэдээлэл бодитой үгүйг тодорхойлж байж, дараа нь юу хийх ёстойг шийдэх хэрэгтэй. Хүндрэлтэй байдлыг хүн болгон мэдэж байгаа. Гэхдээ энэхүү хүндрэлтэй байдлаас хэрхэн гарах вэ гэдгийг шийдэхийн тулд бодит байдлаа сайн мэдэх хэрэгтэй.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРИУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Н.ПУНЦАГБОЛД**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

"Монголын мэдээ" сонин, редакцдад эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

"Ази, Европын түмний 11 дүгээр чуулган"-ы тунхаг бичиг гарчээ

АСЕМ-ын дагалдах хурал болох Ази, Европын түмний 11 дүгээр чуулганыг энэ сарын 4-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа. Уг чуулганаар үндсэн долоон асуудал хэлэлцсэн бөгөөд олон улсын зохион байгуулах хороо /ЮС/ болон үндэсний зохион байгуулах хороо /НОС/ хамтран гарсан дүгнэлтийг нэгтгэн тунхаг бичиг болгон АСЕМ-д өргөн барихаар болсон байна. Энэ талаар өчигдөр Ази, Европын түмний 11 дүгээр

чуулганыг зохион байгуулагч нарын зүгээс мэдээлэл хийлээ. Энэхүү чуулганд иргэний нийгэм болон иргэдийг төлөөлж 42 орны 750 гаруй төлөөлөгч нар оролцсон байна. Үүнээс 210 гадаад орны, орон нутгаас 220 гаруй иргэний нийгмийн төлөөлөл оролцсон, энэ жилийн чуулган өргөн цар хүрээт үйлдвэртэй холбоотой хурал болж өнгөрсөн тухай зохион байгуулагч нар онцлоо. Ази, Европын түмний 11 дүгээр чуулганы үндэсний зохион

байгуулах хорооны дарга Л.Төр-Од "Шударга, тэгш, хүртээмжтэй хөгжлийн арга замыг Ази, Европт хэрэгжүүлэн, эв санааны шинэ нэгдлийг байгуулах нь" сэдвийн хүрээнд долоон асуудлыг тал бүрийн дэмжлэгтэйгээр хэлэлцсэн. Энэ хэлэлцсэн асуудлаараа "Улаанбаатарын тунхаг бичиг", "Улаанбаатарын үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг гаргаж байгаа" гэв. Харин олон улсын зохион байгуулах хорооны гишүүд

"Нийгмийн бүхий л төлөөллийг оролцуулахыг хичээсэн. Энэ жилийн чуулга уулзалт өмнөх 10 уулзалтаас хамгийн сайн зохион байгуулалттай, өндөр ач холбогдолтой хурал боллоо. Энэ чуулганаар хоёр жилд ганц удаа уулзаад зогсохгүй Ази, Европт тивийн хооронд тогтвортой харилцааг үүсгэдэг гүүр гэж хэлж болно. Монголын талаас маш найраг хүлээн авч, хамтарч ажилласан баяртай байна" хэмээн сэтгэгдлээ хуваалцаа.

Х.Баттулгыг гүтгэсэн болохыг шүүх тогтоожээ

УИХ-ын гишүүний тангараг өргөөд буй Л.Эрдэв-Очирын сонгуулийн штабынхан сурталчилгааны явцад айл өрхөөр явж, АН-аас нэр дэвшигч Х.Баттулгыг гүтгэсэн "кино" үзүүдсэн гэх асуудал гарсан билээ. Тэгвэл Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээрх асуудлаар хуралдаж, Л.Эрдэв-Очирын сонгуулийн штабын ажилтан нь Сонгуулийн тухай хууль зөрчсөн болохыг тогтоожээ. Тодруулбал, Б.Мөнхдалай, С.Өнөржаргал хоёр нь Баянхонгор аймгийн Галуут сумын МАН-ын жолооч, ухуулагчаар ажилладаг байж. Энэ талаар Б.Мөнхдалай нь "...айлуудаар орж сурталчилгаа хийхдээ CD бичлэг үзүүдээрэй гэж МАН-ын штабаас өгсөн. ...Түүнийг нь айлаар орж үзүүлсэн. CD нь АН-ын талаар бичлэг байсан" хэмээн шүүхэд гаргасан тайлбартаа хэлжээ. Эцэст нь, шүүх бүрэлдэхүүн "Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5.13 дахь хэсэгт заасан сонгуулийн сурталчилгааны явцад бусдыг гүтгэх, доромжлох, гутаах, хуурамч мэдээ, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр тараасан болох нь нотлогдсон" гэж үзээд МАН-ын ухуулагчийг 1.3 сая төгрөгөөр торгосон байна. Мөн УИХ-ын VII тойрогт МАН-аас нэр дэвшин өрсөлдсөн Г.Занданшатарын төлөө санал өгүүлдэгээр мөнгө тараасан гэдэг нь Баянхонгор аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан

шатны шүүхээр тогтоогджээ. Тухайлбал, Г.Занданшатарын сонгуулийн штаб ажиллахаар Баянхонгор аймагт очсо. О.Долгөн нь УИХ-ын сонгуулийн VI тойрогт нэр дэвшигч Г.Занданшатарын төлөө санал өгүүлдэгээр гурван хүнд мөнгө тараах, үлдэгдэл мөнгийг нь сонгуулийн дараа өгөхөөр хэлцэл хийх замаар Сонгуулийн тухай хуульд заасан хууль бус сурталчилгаа хийсэн болох нь тогтоогджээ. Түүнчлэн тэд "Аймгийн төвийн I ба IV багийн сонгууль өгөх насны бүх хүнд нөлөөлж, Занданшатарыг дэмжүүлэх ёстой гэж хэлээд тийм хүмүүсээ олоод иргэний үнэмлэхний хуулбар, утасны дугаарыг нь авч ирэх ёстой" талаар яришсан байна. Мөн Б.Баттөр гэгч шүүхэд тайлбар өгөхдөө "... Би эхэлсхдээ гурав дахь эгнээнд пирамид маягаар салбарлаж байсан. Тэгэхэд лав 900 гаруй хүн байсан. Би эхлэж ороод өөрийнхөө дор хоёр хүн олно. Тэр хоёр дахиад хоёр хүн гээд салбарлаад явдаг юм" хэмээн сонгогч хэрхэн цуглуулж байгаа талаар ярьжээ. Тэднийг шүүхээс Сонгуулийн тухай хууль зөрчсөн гэж үзсэн байна.

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ СҮМ ДУНДЫН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ ШИЙТГЭВЭР

Захирааны шийтгэл ногдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүх Б.Ганзориг би Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн Б.Цэдэвдоржийн ир. "Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал хурааж дуусгах үргэлж хуульдаа Улсын Их Хурлын сонгуулийн 7 дугаар тойрогт Монгол Ардын намаас нэр дэвшигч Г.Занданшатар болон түүний сонгуулийн штабыас сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор мөнгө тараасан сонгуулийн дүн гарсны дараа мөнгө өгөхөөр амласан сонгуулийн дүн гарсан боловч мөнгө өгөөгүй тохиоллоод байна." гэсэн зарчгийн 1.2016 оны 07 сарын 04-ний өдөр тус шүүхэд ирүүлснийг үлгэн авч хийжээ.

ТӨДӨНХОЙЛОХ нь...

ХИМЭЭД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ СҮМ ДУНДЫН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ ШИЙТГЭВЭР

Захирааны шийтгэл ногдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүх Б.Ганзориг би Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн Б.Цэдэвдоржийн ир. "Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал хурааж дуусгах үргэлж хуульдаа Улсын Их Хурлын сонгуулийн 7 дугаар тойрогт Монгол Ардын намаас нэр дэвшигч Г.Занданшатар болон түүний сонгуулийн штабыас сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор мөнгө тараасан сонгуулийн дүн гарсны дараа мөнгө өгөхөөр амласан, ирсэн боловч мөнгө өгөөгүй тохиоллоод байна." гэсэн зарчгийн 1.2016 оны 07 сарын 04-ний өдөр тус шүүхэд ирүүлснийг үлгэн авч хийжээ.

ТӨДӨНХОЙЛОХ нь...

ХИМЭЭД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ СҮМ ДУНДЫН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХ ШИЙТГЭВЭР

Захирааны шийтгэл ногдуулах тухай

Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүх Б.Ганзориг би Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн Б.Цэдэвдоржийн ир. "Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш санал хурааж дуусгах үргэлж хуульдаа Улсын Их Хурлын сонгуулийн 7 дугаар тойрогт Монгол Ардын намаас нэр дэвшигч Г.Занданшатар болон түүний сонгуулийн штабыас сонгогчдын саналыг худалдан авах зорилгоор мөнгө тараасан сонгуулийн дүн гарсны дараа мөнгө өгөхөөр амласан, ирсэн боловч мөнгө өгөөгүй тохиоллоод байна." гэсэн зарчгийн 1.2016 оны 07 сарын 04-ний өдөр тус шүүхэд ирүүлснийг үлгэн авч хийжээ.

ТӨДӨНХОЙЛОХ нь...

ХИМЭЭД

Байнгын хороодыг байгуулж, бүрэлдэхүүнийг нь баталлаа

УИХ-ын чуулганы хуралдаан 69.7 хувийн ирцтэй хуралдаж, байнгын хороодын бүрэлдэхүүн батлах тухай тогтоолын төслийг хэлэлцлээ. Төрийн байгуулалтын, Байгаль орчин, Хүнс, хөдөө аж ахуйн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны, Өргөдлийн, Төрийн байгуулалтын, Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнийг танилцуулж, гишүүдийн олонхийн саналаар батлав. УИХ-ын дэгийн тухай хуулийн дагуу нэг гишүүн гурван байнгын хороонд хамрагдах эрхтэй байдаг. Энэ дагуу намын бүлгүүдээс ирсэн саналын дагуу байнгын хороодын гишүүдийн хуваарилалтыг хийсэн байна. Хуралдааны үеэр УИХ-ын гишүүн С.Бямбацогт "УИХ-ын цөөнхийн бүлгийн гишүүдийг тус тус гурван байнгын хороонд харьяалагдсан байна. Тиймээс та бүхэн хуралдаа сайн суугаарай. Бид өнгөрсөн дөрвөн жилд цөөнх байхын зөвлонг амссан. Байнгын хороод дээр бүлгийн ирд дутах, завсарлага авах боломж бүрдэхгүй байх зэргээр олон асуудал үүсдэг" гэж тодотгосон юм. УИХ-ын гишүүн Г.Мөнхцэцэг "Би боловсролын сургууль төгсч, соёлын салбарт насаараа ажилласан хүн. Гэтэл намайг Өргөдлийн байнгын хороонд хамруулсан байна. Энд андуурал гарч" гэхэд УИХ-ын дарга М.Энхболд "МАН-ын бүлгээс ирсэн саналын дагуу та Өргөдлийн байнгын хороонд харьяалагдсан байна" гэсэн хариулт өгсөн юм. Үүний дараа үргэлжлүүлэн байнгын хороод чуулган дээр батлагдасан бүрэлдэхүүнээр хуралдаанаа хийж, даргаа сонгохоор болов.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

ХЭН ЮУ ХЭЛЭВ

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

М.Энхболд: Бид төрийн өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, цэгц шударга, эрч хүчтэй олонхи байх болно

/УИХ-ын дарга/

Монгол Улсын Их Хурлын долоо дахь удаагийн сонгуулийн анхдугаар чуулганы хуралдаанд УИХ-ын дарга М.Энхболд үг хэлсэн юм. Тэрбээр “Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуульд идэвхтэй оролцож зөв мэргэн сонголт хийсэн туурга тусгаар Монгол орныхоо бүрэн эрхт ард түмэндээ гүн талархал илэрхийлж. УИХ-ын сонгууль хуульд заасан журмын дагуу зохих ёсоор зохион байгуулагдсан гэж үзэж, Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ын анхдугаар чуулганы зарлан хуралдууллаа. УИХ-ын ээлжит сонгуульд сонгогч түмнийхээ итгэлийг хүлээж, төрийн сүлдэндээ сүслэн гишүүний тангарга өргөсөн УИХ-ын эрхэм гишүүдээ баяр хүргэе. Өнөөдөр УИХ-ын 76 гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч, гишүүд тангаргаа өргөснөөр төрийн эрх барих дээд байгууллага УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүтэн бүрэлдэхүүнтэй боллоо. УИХ-ын даргын өндөр хүндтэй албан тушаалд нэрийг минь дэвшүүлсэн МАН, сонгож батламжилсан УИХ-ын эрхэм гишүүдээ талархал илэрхийлж. Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга зарчим, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зэрэг Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг чанд баримтлан ажиллах болно. УИХ-ын гишүүний тангаргаа өргөсөн энэ мөчид УИХ-аас нэн тэргүүнд хэлэлцэн шийдвэрлэх асуудлууд байгаад та бүхний анхаарлыг хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Бид мэргэжлийн Засгийн газрыг байгуулж нэн даруй үйл ажиллагааг нь эхлүүлэх шаардлагатай байна. Салбарынхаа үйл ажиллагааг бүхий л талаас нь мэддэг, мэргэшсэн төрийн зүтгэлтнээр Засгийн газрыг бүрдүүлж, төр, засгийн тогтвортой ажиллах нөхцөлийг хангана. Улс орноо өнөөгийн хямралт байдлаас гаргахын тулд шинээр бүрэлдэх Засгийн газар богино хугацаанд эдийн засгийг тогтворжуулах тусгай хөтөлбөр боловсруулан УИХ-аар батлуулах хэрэгтэй. Хуулийн хугацаанд батлах ёстой зарим асуудал өмнөх УИХ-ын



үед шийдвэрлэгдэж чадалгүй үлдсэн байна. Тухайлбал, 2017 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018, 2019 оны төсвийн хүрээний төсөөлөл батлагдаагүй. Энэ оны төсөвт яаралтай тодотгол хийх шаардлага ч тулгарч байна. Наадмын дараа намар гэдэг. Шинээр байгуулагдах Засгийн газар, улс орны өвөлжилтийн бэлтгэлийг хангах Үндэсний их баяр наадам болон АСЕМ-ийн дээд хэмжээний чуулганыг өндөр хэмжээнд зохион байгуулах, даян дэлхийн энх тайвнайрамдлын бэлтгэлд өгөх болсон Олимпын наадам оролцох багийн бэлтгэлийг хангах зэрэгт онцгой анхаарч ажиллах хэрэгтэй байна. Бид төрийн өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, цэгц шударга, эрч хүчтэй олонхи байх болно. Бид намынхаа сонгуулийн мөрийн хөтөлбөрт үндэслэн ирэх дөрвөн жилийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж, бүрэн дүүрэн хэрэгжүүлнэ. Сөхөрсөн эдийн засгаа хөл дээр нь босгож, дундуур бүхнээ дүүргэн, дутуу бүхнийг бүтээж, айл өрх бүрийн амьжиргааг дээшлүүлэхийн төлөө бүхий л хүчээ дайчлан хичээнгүйлэн зүтгэх болно” хэмээсэн юм.

Э.Бат-Үүл: Та нар пянг нь даахгүй шүү

/Нийслэлийн Засаг дарга асан, НИТХ-ын төлөөлөгч/

НИТХ-ын анхдугаар хуралдаанаар нийслэлийн ИТХ-ын сонгууль явуулсан дүн, шинээр сонгогдсон төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрч, нийслэлийн ИТХ-ын даргаар нийслэлийн МАН-ын дарга Ц.Сандуйг сонгосон юм. НИТХ-ын даргыг сонгохын өмнө иргэдийн төлөөлөгчид НИТХ-ын даргад нэр дэвшигч Ц.Сандуйгаас 60 тэрбумыг босгох тухай буюу нийтэд тарсан бичлэгийн талаар асууж байв. Энэ асуултад тэрбээр "Энэ бол сонгуулийн гүтгэлэг байсан. Би хуулийн байгууллагад шалгуулахаар хандсан. Хэрэв миний буруутай үйлдэл хэмээн тогтоогдвол хариуцлага хүлээхэд бэлэн" хэмээн хариулсан. Харин АН-ын төлөөлөгчид энэ асуудлыг ингээд орхихгүй. Шүүх,

цагдаагийн байгууллагаар шалгуулах болно гэдгийг сануулж байлаа. Үүний дараа санал хураахын өмнө НИТХ-ын дарга Т.Баттулга үг хэлэхдээ Ц.Сандуйгийн 60 тэрбумыг босгох тухай асуудал түүнийг дарга болбол байнга яригдах болно. Бид шалгуулах болно гэдгээ дуулгасан. Үүний дараа буюу санал хураахын өмнө нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүл "Та нартай юу ч булаацалдаагүй. Сонгуулийн дүнгээ зөвшөөрөөд, та бүхэнд тайван замаар эрх мэдлээ шилжүүлэх ардчиллын гайхамшиг бий шүү гэдгийг хэлж байхад та бүхэн олуулаа орилж, найрал дуу шиг дайрч байгаа нь маш том алдлаа. Битгий ийм үйлдэл гарга гэж зөвлөж байна. Та нар пянг нь даахгүй шүү. Би дахиад хэлбэ. Эсэргүүцлийн хөдөлгөөн зохион байгуулах арга, нэр хүнд болоод туршлагыг гартаа атгачихсан хүмүүс гудамжинд гарчихсан байгаа шүү. Тиймээс битгий ингэж аархуу загнаарай. Би та нарын сайн сайхны төлөө, нийгмийн болоод ардчиллын аюулгүй байдал, эрх ашгийн төлөө хэлж байна. Би сонгуулийн дараа зоринд тайван замаар засгийн эрх шилждэг, энэ ардчиллын гайхамшигийг үзүүлсэн сонгууль боллоо гэдгийг санамсаргүй хэлээгүй. Түүнчлэн энэ НИТХ бол өнөөдөр нийслэлдээ нэр хүндээрээ парламенттайгаа өрсөлдсөн хурал болж чадсан. Өөрөөр хэлбэл, УИХ-тайгаа өрсөдөхүйц хурал болсон. Тэгэхээр ийм хурлын нэр төрийн асуудал гэж байдаг юм. Гэтэл одоо анхнаасаа л нэр төр нь асуудалд орж, нэр төр нь эргэлзээнд орно гэдэг бол аюул байдаг. Та нар үнэмлэхүй олонхи. Тиймээс хэнийг сонгох нь бүрэн эрхийн асуудал. Гэхдээ иргэдийн хурал гэж нэрлэсэн учрыг сайн бод. ИРГЭД-ийн хурал гэдэг юм шүү. Тиймээс ИТХ-ын нэр төрийн асуудал маш чухлаар тавигдах учиртай.

Анхнаасаа л ард түмэнд итгэл найдвар төрүүлсэн буюу онцгүй зүйлийн гай болчихооргүй иргэдийн хурал байх ёстой. Гэхдээ нэгэнт л үнэмлэхүй ялсан та бүхэн шийдвэрээ гарга. Тухайн шийдвэрийн дагуу л явна. Уучлаарай би бол эсрэг санал өгөх нь ойлгомжтой. Яагаад гэвэл иргэдийн хурлын нэр төрийг унагах хүнийг дэмжихгүй. Т.Баттулгын хэлдэг үнэн. Ц.Сандуйгийн 60 тэрбумыг босгох тухай асуудал олон түмний анхааралд орчихсон ноцтой асуудал. Тиймээс энэ асуудал нь түүнийг дарга болсон ч салахгүй. Тиймээс та бүхэн жаахан даруухан байгаарай. Би хэлж байсан. Алан хядагч шиг нүүрээ нуугаад бүтэн байгуулалтыг эсэргүүцдэг хүмүүсийг би лалар гэж хэлсэн. Харин тэр нь хэн байсныг одоо олж харлаа” хэмээн хатуухан үг чулууаад амжсан юм.

Ц.Нямдорж: Дээрээ ард түмэнтэй, дэргэдээ сөрөг хүчинтэй гэдгийг манай намынхан битгий мартаарай

/УИХ-ын дэд дарга, УИХ-ын гишүүн/

УИХ-ын долоо дахь удаагийн анхдугаар чуулган эхэлж, гишүүд СЕХ-ны дарга Ч.Содномцэрэнгээс асуулт асууж байх үед УИХ-ын гишүүн Ц.Нямдорж үгээ хэлж, асуулт асуусан. Тэрбээр “Засаглах онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлсэн ард түмэндээ баярлаж сууна. Намайг сонгосон 56 дугаар тойргийн сонгогч нартаа баярлалаа. 2004 онд будилаан, маргаан гарсан. 2008 онд бас маргаан гарсан. 2012 онд юу болсон билээ. Харин энэ удаад ард түмэн хаан шийдвэрээ гаргаж тайван сонгууль боллоо. Энэ сонгуулийг хуучин эрх барьж байсан хүмүүс удирдсан

болохоор маргаан гарахгүй л болов уу. Сонгуулийг амжилттай зохион байгуулсан СЕХ-ны нөхдүүдэд баярласнаа илэрхийлж. Сүүлийн жилүүдэд байхгүй тайван сонгууль болж өндөрлөвөө. Түүнээс гадна би нэг зүйлийг хэлмээр байна. Дээрээ ард түмэнтэй, дэргэдээ сөрөг хүчинтэй гэдгийг аль ч үеийн парламентынхан битгий мартаарай. Мөн 65 суудал авсан намынхаа нөхдөд зоринд захиж хэлмээр байна. Эрх баригчид хууль битгий зөрчөөрэй, алдаа битгий гаргаарай гэдгийг ч сануулж хэлмээр байна” хэмээсэн нь олны анхаарлыг татсан.

Ө.Энхтүвшин: МАН-ын дарга УИХ-ын даргаар сонгогдож буйг би хувьдаа дэмжихгүй байна

/УИХ-ын гишүүн/

УИХ-ын чуулганы анхдугаар хуралдаанаар хэлэлцсэн хамгийн эхний асуудал бол УИХ-ын даргыг сонгох тухай асуудал байсан. УИХ-ын гишүүдийн дийлэнхийн саналаар УИХ-ын гишүүн, МАН-ын дарга М.Энхболд УИХ-ын дарга болсон юм. Үүний дараа УИХ-ын даргад хандаж гишүүд байр сууриа илэрхийлж, баярхувраг. Энэ үеэр УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин “Шинээр сонгогдсон, тангаргаа өргөсөн бүх хүмүүст баяр хүргэе. Ажилд нь өндөр амжилт хүсье. МАН-ын дарга УИХ-ын даргаар сонгогдож буйг би хувьдаа дэмжихгүй байна. Ялсан намын дарга Ерөнхий сайд болж сонгуулийн амлалтаа хэрэгжүүлдэг, фронтын тэргүүн эгнээнд л явдаг байх ёстой. Харин одоо Засгийн газрын томилгоог хийхэд туйлын хариуцлагатай хандах хэрэгтэй. Ачааны хүнд Монгол Улсын Засгийн газарт ирнэ. Сонгуулийн амлалтыг Монгол Улсын Засгийн газар, тэргүүн нь хариуцна. Мөн амласан амлалтаасаа ухарч болохгүй шүү гэдгийг намынхаа нөхдөд хэлмээр байна. Нэг үгтэй, нэг нүүртэй байх ёстой шүү. Сонгуулийн өмнө нэг зүйл яриад дараа нь өөр юм ярьдаг байж болохгүй” хэмээлээ.

Хотол түмнээрээ сайхан наадаарай

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Наадмын нээлтийг урьд жилүүдийнхээс өвөрмөц, өөр болох болов уу гэж харж байгаа. Анх удаа энэ жил наадмын сүлд дуу нээлтийн ёслол дээр эгшиглэхээр болоод байна. Эх орны тухай олон дуучин дуулахад зориулсан дуу хийдгээрээ алдартай Ш.Гурбазар, Х.Балжжав хоёр гавьяат наадмын тухай сайхан дуу зохиосон байна билээ. Дээрээ нь УДЭТ-ын найруулагч Б.Наранбаатар энэ жил наадмын нээлтийн тоглолтыг найруулж байгаа. Энэ хүнээс үзэгчид дандаа л шинэ, шинэлэг, өөр зүйлийг хүлээж байдаг. Үзэгчдийн хүлээлтэд хүрэх байх. Ер нь сүүлийн жилүүдэд наадмаар үзэж харах зүйл ихтэй болоод байгаа. Мэдээж бөхийн барилдаан, хурдан морины уралдаан, сур харваанаас гадна шүү дээ. Хотын удирдлагууд “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш жуулчид болоод Монголын иргэдэд зориулсан олон соёлын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа. Энэ жил “Монгол хуушуур-2016” фестиваль болдоггоороо болно. Хамгийн сайхан хуушуур хийж байгаа хүмүүсийг хооронд нь уралдуулах юм билээ. Мөн наадамчин олонд зориулсан АХА гэмцээнээс гадна олон сонирхолтой үйл ажиллагаа болохоор байсан. Энэ мэтээр үзэгчдэд үзэх зүйл их бий. Хүй долоон худалт ч гэсэн иргэд ая тухтай наадах бүхий л боломжоор хангаж өгч байгаа. Хэдхэн жилийн өмнө бужигнасан тоосон дунд наадамладаг байсан цаг ард хоцорсон. Энэ жил Хүй долоон худал руу рэйлбус явна. Улмаар рэйлбусаас буусан наадамчдыг автобусаар үнэгүй зөөх юм билээ. Энэ мэтээр жил ирэх тусам наадам сайхан болсоор л байна. Яахав, жилийн жилд гардаг ганц нэг хэцүүхэн асуудлууд дахиад л давтагдахаа. Наадмын тасалбарыг тулгаж зардгаас болоод ургаас урт дараалал үүсдэг. Энэ жил ч гэсэн усан борооноор иргэд наадмын тасалбар авах гээд л дараалалд зогслоо. Цаашлаад наадмын өдөр шагийн тасалбарын үнэ хэд ч хүрэхийг хэн мэдлээ. Нэг иймэрхүү асуудлыг дараа дараачийн жилээс зохицуулмаар байгаа юм. Үүнээс өөр өөлөөд байх юм алга. Энэ жил түрүүлсэн бөхөд цоо шинэ Ланд-200 автомашин өгөхөөр болоод байгаа. Хэн гэдэг хүчтэн нь наадамдаа түрүүлж, цолоо нэмж, 1024 бөхийн магнайд гарч, цоо шинэ төмөр хүлгээр шагнуулахыг ердөө дөрөвхөн хоногийн дараа бид харна. Энэ жилийн наадам ч сайхан болно доо. Дэлхий дэлгэнэж, дэнж ногоорч, дэлгэр Монголын дээлтэй монголчуудын сэтгэл тэнгэр байна. Эртэй баяртай бөхчүүдээ биширч, эрэмгий хурдан хүлгийнхээ хөлснөөс адис авдаг, эрхий мэргэн харваачдын уухайн дуунд хөглөгддөг миний ард түмэн сайхан наадаарай.



ТУЛГАР ТӨРИЙН 2225 ЖИЛ, ИХ МОНГОЛ УЛС БАЙГУУЛАГДСАНЫ 810 ЖИЛ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН МЭНДИЙГ ХҮРГЭЭ САЙХАН НААДААРАЙ



АРДЧИЛСАН НАМ

ЭНТЕРТАЙНМЭНТ

УРАН БҮТЭЭЛЧ

С.НАРАН:

Хувь тавилан намайг хөтөлж дуурин болгосон

мөрөөдөл үү. Яагаад жүжигчин мэргэжил эзэмшсэн юм бэ?

“Шар” Пагма гээд дууддаг охин байсан юм. Нэг өдөр би Орос хэлдээ бэлтгэх гээд багшийнх руугаа явж байтал Драммын театрын үүднээс “шар” Пагма намайг далладаг юм байна. Очсон чинь энд Кино драмын ангийн шалгалт авч байна, хоёулаа хамт өгөх үү гэлээ. Тэгээд л сонирхоод шалгалт өгсөн чинь тэнцчихсэн. Эхний өдөр нь шуу, бүр. Хүний хувь тавилан өөрийн эрхгүй л хөтөлдөг юм билээ. Би дуучин болно гэж боддоггүй байсан. Гэхдээ багаасаа л дуулж байлаа. Миний амьдралын замнал энэ л байж. Ямар замаар явах ёстойг багаас минь л надад зааж өгсөн хэрэг. Урлагаас өөр замаар явсангүй. Зөв замаар явж байгаа гэж боддог юм.

-Аав, ээжийнхээ тухай ярих?

-Манай аав Хөвсгөлийн модны үйлдвэрийн дарга хийж байсан. Ой хамгаалах, модны үйлдвэрийн ажилчдыг удирдах ажлыг олон жил хийсэн дээ. Шинэ бүтээл, оновчтой санал олон гаргаж байсан. Хөдөлмөрийн багтрууд олон төрж байлаа. Аавыгаа дагаж хөдөө нутгаар тосгоны модны цехээр хамт явдаг байлаа. Их сайхан дурсамж үлдэж. Ажилчид, үйлдвэр надад их аугаа санагддаг, түүнийг удирдаж байгаа ааваараа их бахархдаг байлаа. Манай ээж тогтооч байсан. Сайхан сэтгэлтэй үр хүүхдийнхээ талаар ятгашгүй тэмцэгч, дайчин, ухаантай эмэгтэй байсан юм. Хэр барагтай бол биднийг загнаад байхгүй ч нэг загнахдаа ширүүн бууна шүү. /инээв/ Биднийг маш цэвэрч байгаж сургасан. Хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй хүүхэдтэй айлын гуравдахь хүүхэд. Доороо нэг дүүтэй. Хөвсгөлд одоо аавын маань ах дүү, миний төрсөн ах амьдарч байна. Би нутаг усныхандаа хайртай. Тэнд амьдарч буй бүх хүнийг хайрладаг. Хөвсгөл гэдэг нэрээр овоглож яваа хэн бүхэн сайн нэртэй, сайхан амьдраасай гэж хүсдэг. Хөвсгөлийн мангар гэх хэлүүлэх дургүй. Хөвсгөлийнхэн ухаантай юм гэж хэлүүлэх дуртай. Бид заавал нэг зүйлээрээ илүү байх ёстой шүү. Нэг зүйлийн төлөө тууштай явж, нүгтийн энергийг сайнаар ашиглах хэрэгтэй.

-Хөвсгөл нутгийн ард түмэн олон зүйлээрээ бахархах дуртай. Таны хувьд нутгийнхаа юугаар нь илүү бахархаж ярих юм?

-Монголд байгаа хамгийн сайхан нуур Хөвсгөлд байна. Уул усанд ойрхон өссөн учраас би модтой уул харахгүйгээр байж чаддаггүй. Энд тэнд очихдоо мод, устай газраар явж байж л байгальд гарсан мэдрэмж төрдөг. Өндөр ууланд гарч сэтгэлээ тайтгаруулдаг байсан маань их

үгүйлэгддэг юм. Тийм ч учраас ууланд гарч хашгирах их дуртай. Уулнаас энерги авч, ертөнцийг мэдрэх сайхан шүү.

-Хөвсгөлөөс төрсөн дуучид хүчтэй хоолойтой, уран бүтээл нь ч хүчирхэг онгодтой байдаг гэх юм билээ?

-Үнэн шүү. Аугаа их орон зайтай нутаг шүү дээ. Гайхамшигтай. Дархадын цэнхэр хотгорыг чи мэдэх л байлгүй. Үгээр хэлэмгүй гайхалтай онгон байгальтай. Тийм байгальд өссөн хүмүүс чинь урлаг, уран зохиолд онгодтой орохоос яах билээ. Байгалиа түшиж амьдралаа гэдэг сайхан мэдрэмж.

-Таныг Ө.Уянга гавьяаттай хамтран дуулсан “Нутгаа дуулахуй” уран бүтээлийнхээ

...Магтууштай тал маш их. Технологийн эрин үед бид амьдарч байна. Нээлттэй байх, өөрөө өөрийгөө үнэлэх үнэлэмж манай залууст нэмэгдсэн. Бусадтай цагаахнаар өрсөлддөг болж. Зарим нь УИХ-д нэр дэвшч үзлээ. Монголын нэг хэсэг гэдгээ мэдэрдэг, чадвараа бусдаар үнэлүүлэх гэдэг зөв хандлага бий болсон байна, залууст маань. Энэ маш чухал. Өөрийгөө муугаар мэдэрч болохгүй. Энэ амьдралд мэдрэмжтэй амьдрах чухал. Тэр тусмаа залуус...

аялууг өөрөө бичсэн гэдэг юм билээ. Ямар сэрэл мэдрэмж, сэдлээр бүтсэн дуу вэ?

-Хөгжмийн найруулагчид Гантөр ихтусалж хийж өгсөн. Ш.Гүрбазар ахад захиалга өгч үгийг нь бичүүлж байсан. Ө.Уянгатай дуулаа гэж бодсон байсан учраас хамт дуулсан. Үнэхээр сайхан уран бүтээл болсон. Омогшмоор. Далайн эрэгт хясаан дээр гарч дуулж байлаа.

-Уран бүтээлийн олз омог хэр арвин байна. Шинэ уран бүтээл дээр ажиллаж байна уу?

-Бид чинь өдөр болгон л элдвийн үйл ажиллагаанд уригдана шүү дээ. Ертөнцийн баяр ёслол дуусахгүй юм. Төрсөн өдөр,

хурим, тоглолт, хүлээн авалт гээд л үргэлжилнэ. Нэг мэдэхэд л олон жил дуулчихаж. Маш олон цомог гаргасан. Залуудаа их ажилласан учраас үр шимийг нь хүртээд л амьдарч байна. Намраас шинэ цомгийнхоо ажилд орно.

-Олон улс руу чиглэсэн ажил төлөвлөж байна уу. Сүүлийн үед шоунд шүүгч хийгээд яваа харагдах юм?

-Таван хэлээр цомгоо гаргачихлаа. Гадны хөгжмийн зохиолч болон продессоруудтай хамтарч ажиллах бодол бий. Одоо ямар сонирхолтой уран бүтээл хийх вэ гэдэгт илүү анхаардаг болсон. Тэмцээн уралдаан шүүнэ гэдэг маш хэцүү. Үзэгчид маш их мэдлэгтэй болчихсон. Бас хүмүүжсэн. Дуу дуулах гэдэг чинь ийм зүйл байдаг, ялгаа нь энэ бүтээлийг мэдэрдэг учраас дуучдын чанар ч сайжирдаг. Үзэгчийн мэдрэмж өөрөө урлагийн үнэ цэнийг тодорхойлж явдаг. Тиймээс тэмцээнд уралдаанд шүүгч хийгээд сууж байхдаа үзэгчдээ ч хүмүүжүүлж, мөн урлагаа ч үнэ цэнэтэй болгоход хувь нэмрээ оруулж байна гэж бодож байгаа.

-Өнөөгийн залуус хэтэрхий бэлэнчилдэг гээд л шүүмжлэх нь их бий. Тэгвэл залуу үе яагаад нэг удаа магтаж болохгүй гэж. Та залуусдаа нэг сайхан урмын үг хэлээч?

-Магтууштай тал маш их. Технологийн эрин үед бид амьдарч байна. Нээлттэй байх, өөрөө өөрийгөө үнэлэх үнэлэмж манай залууст нэмэгдсэн. Бусадтай цагаахнаар өрсөлддөг болж. Зарим нь УИХ-д нэр дэвшч үзлээ. Монголын нэг хэсэг гэдгээ мэдэрдэг, чадвараа бусдаар үнэлүүлэх гэдэг зөв хандлага бий болсон байна, залууст маань. Энэ маш чухал. Өөрийгөө муугаар мэдэрч болохгүй. Энэ амьдралд мэдрэмжтэй амьдрах чухал. Тэр тусмаа залуус. Бидний үеийг бодоход өрсөлдөөн их болсон байна. Юу чаддагаараа өрсөлдөж, тэмцэлдэж, нэр төрийг өндөрт өргөх гэж хичээдэг болжээ.

Худлаа яриад энэ нийгэмд багтахаа больсон. Эсвэл арын хаалгаар амьдралд хол тавиад урагшаа ахихаа больсон байна. Үүнийг залуус маань маш сайн ухаарчихаж. Үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлж буй эцэг, эхээс маш их шалтгаалдаг. Яаж хүмүүжүүлснээс орчин тойрноо хэрхэн яаж хамгаалах вэ гэдэг сэтгэхүй суудаг. Хотоо хайрлах, нутаг усаа хамгаалах, өмгөөлөх, цэвэрхэн цэмцгэр байлгах сэтгэлтэй байна гэдэг маш чухал. Биднийг хүүхэд байхад хүн бүр бага балчраас эхлэн туйлын арвич хямгач гээд л ягштал цээжлүүлдэг байлаа. Өнөөдрийг хүртэл баримтлаад л явж байна. Миний үеийнхэн одоо эмээ өвөө болох гэж байна. Хүүхдүүд нь хөдийнэ ажил амьдралд гараад эхэлчихэж.

Тэгэхээр миний найзууд, миний үеийнхэн үр хүүхдээ зөв хүмүүжүүлж чадсан гэж итгэж явдаг. Би улс орондоо дуугаараа хувь нэмэр оруулж, залуу үедээ үлгэр дуурин болж явна.

-Таныг хог хаягдал дахин ашиглах төсөл хэрэгжүүлж байгаа гэсэн. Хэр амжилттай урагшилж байна вэ?

-Дуулахын хажуугаар дахивар ноёцийг ашиглах, буцааж бүтээгдэхүүн болгох, байгаль орчноо хамгаалах “ДЭКО” төсөл санаачиллаа. Дизайнертай хамтарсан. Төсөл маань амжилттай хэрэгжиж завгүй явж байна. Орчин тойрондоо байгаа хог хаягдлыг хаягдал бишээр харж чаддаг, бүтээгдэхүүн болгож бүтээгдэхүүн болгож чаддаг байвал шуналаас холдох зам эхлээд тавина. Бид шуналтай биш бүтээлч байх ёстой. Хүн өөрсдөө бүтээхгүй атлаа бүтээснийг хэрэглээд шууд хаячихдаг. Тэгвэл тэр хаягдлыг яагаад эргээд бүтээл болгож болохгүй гэж. Би залуу үе, залуусыгаа бүтээлч байгаасай гэж хүсдэг. Нутагтаа “ДЭКО” төслөөр олон ажил хийх бодолтой байгаа. Хөрөнгө мөнгө дутагдах гээд бэрхшээл гарч ирдэг л юм. Гэхдээ энэ бол асуудал биш. Аливаа зүйлийг хүндрэлтэй талаас харвал бүтээхгүй. Би бэрхшээлтэй тулгарах бүртгээ баярладаг. Яагаад гэвэл, тэндээс маш их туршлага харимтлуулдаг юм. Хөрөнгө санхүү дутвал өөрөөсөө гаргаад л хийчихнэ. Миний ажлыг ойлгоод ирэхээр хүмүүс дэмжээд л явдаг. Бид эхлээд үлгэрлэх ёстой. Тэр цагт үргэлжлүүлээд хийх хүн зөндөө бий. Монголчууд чинь сэргэлэн ард түмэн. Түүнийг нь сэргээх чухал.

-Та улс төрийн хувьд хэр идэвхтэй хүн бэ. Өнөө жилийн сонгууль урлагийн төлөөллөөс чамгүй орж ирлээ. Асуухгүй өнгөрч боломгүй нь?

-Ер нь идэвхтэй шүү. Улс төрийг маш зөв хүмүүс удирдах ёстой. Заримдаа тогтоод харахаар сайнаасаа саар нь их байх юм. Чадваргүй, амьдралыг ойлгохгүй, гараа зөв зүйлд дурж үзээгүй хүмүүс олон байгаа. Зөвөөр мөнгө олж үзээгүй хүмүүс төрд байгааг хараад харамсдаг л юм. Амнаас гарч байгаа үг нь энэ хүн зөв мөртэй явсан уу гэдгийг харуулчихдаг. Юу мэддэг, ямар хүчээр улс төрд орж ирвэ, ард түмний эрх ашгийн төлөө ажиллаж чадах уу гэдгээ амнаас гарч байгаа үгээрээ илэрхийлдэг учраас би үгийг нь сонсоод л хэн бэ гэдгийг нь ойлгодог. Дундаа авч байгаа амьсгаа, үгийн сонголтоосоо эхлээд л танигдчихдаг. Ард түмэн тэнэг биш. Тиймээс худлаа ярьж, хуурч өрөөсөө болохгүй. Шударгаар чинь үнэнч явбал амьдралын замд үргэлж амжилт утгаж байдаг юм шүү дээ. Тиймээс урлагийн маань хөгжлийн төлөө төрд сууж байгаа хүмүүс шударгаар, үнэнээр яваасай л гэж хүсье.



Б.ӨНӨРТОГТОХ

Монголын поп дива нарын нэг, МУСТА С.Наранг “Уран бүтээлч” буландаа урьж ярилцлаа. Хүчирхэг дуу хоолой, ягаан үс, хар нүдний шилийг илгиж болгосон Хөвсгөл нутгийн дуучинтай энэ удаад уран бүтээл, хүүхэд нас, нутаг усны талаар сонирхолтой ярилцлага өрнүүлсэн юм.

-Хөвсгөлийн С.Наранг монголчууд төдийгүй дэлхий танина. Хүчирхэг дуу хоолойтой дуучин бүсгүй маань багадаа ямар хүүхэд байсан нь уншигчдад сонирхолтой байх болов уу. Хэр дэггүй охин байв?

-Би Хөвсгөл аймгийн Мөрөн хотын хоёрдугаар 10 жилд аравдугаар анги хүртлээ суралцаж төгссөн. Аравдугаар ангиа төгсөөд Кино драмын ангид 1991 онд элсэн суралцаж байлаа. Хүүхэд байхдаа ер нь

хөдөлгөөнтэй хүүхэд байсан шүү. Олон нийтийн ажилд идэвхтэй, дуулж хуурддаг, анги хамт олноо, найз нөхдөө олон нийтийн ажилд их уриалдаг хүүхэд байсан. Хүүхэд нас мэдээж гэгээлэг, цагаахан. Би социалист нийгэмд өсч төрж, хүмүүжсэн гэдгээрээ бахархдаг. Хүний зан чанар эвдрээгүй, аюулгүй, муухай юм тэр болгон хүнээс гараад байдаггүй тийм цаг үед өсч хүмүүжсэн гэдгээрээ бахархдаг. Тэр үед хүүхэд байсан хүмүүсийн хүмүүжил их өөр байдаг шүү.

-Дуучин болох таны багын

НӨӨЛТӨЙ ТЕНДЕРИЙН УРИЛГА

нь 50,000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь дараах шаардлагуудыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Тендерт оролцогчийн сүүлийн нэг жил /2015 он/-ийн борлуулалтын орлого нь санал болгож байгаа үнийн дүнгийн 50%-иас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой эзэлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 50 %-иас багагүй байх

Баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2014 он 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан.

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна. /2014 он 2015 он/

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2014 он 2015 он/

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тендерийн баримт бичигт дэлгэрэнгүй тусгасан болно.

Тендерийг 2016 оны 08 дугаар сарын 08-ний 10 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2016 оны 08 дугаар сарын 08-ний өдрийн 10:30 цагт нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд дотоодын давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Төлбөр хийх хэлбэр: Дансаар тушаана
Банкны нэр: Голomt банк
Дансны дугаар : 1205024548

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБ хот. Сонгино хайрхан дүүрэг 18-р хороо, Авто тав ХК-ний байр Утас: 9703-2420, 99069416

ЦАГ ҮЕ

ТОМИЛОЛТ

УСАН ЗАМЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ҮНДЭСНИЙ СЕМИНАР БОЛЛОО



Н.БАТЗАЯА

Дэлхийн цэнгэг усны нөөцийн хоёр хувь, Монголын газрын гадарга дээрх цэнгэг усны нөөцийн 75 хувийг бүрдүүлдэг Хөвсгөл нуур дахь тээврийн аюулгүй үйл ажиллагааны үндэсний семинар энэ сарын 6-7-нд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд боллоо. Одоогоос 10 жилийн өмнө Монгол орны хойморт залрах далай ээжийн үзэсгэлэнт байгалийг харах гэж жилд 6-8 мянган дотоодын болон гадаадын жуулчин ирдэг байсан аж. Тэгвэл эдүгээ 60 мянган жуулчин ирэх болжээ. Жуулчдын тоо нэмэгдсэн, цаашид өсөх хандлагатай байгаа энэ үед нуур дахь тээвэрлэлтийн аюулгүй үйл ажиллагааг хангах, тэр дундаа зорчигчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үндэсний болон боловсон хүчинг бэлтгэх нэн тэргүүний шаардлага манай улсад байна. Тиймээс Зам тээврийн яамны харьяа Далайн захиргааны байгууллагын санаачилгаар Зам тээврийн яам, Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар, Олон улсын далайн байгууллага, Олон улсын эрэн хайх, авран туслах холбоо хамтран “Монгол Улсын усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” үндэсний семинарыг зохион байгууллаа. Энэхүү семинарт, Далайн захиргааны дарга Х.Энхбаатар, Хөвсгөл БОНХАЖА-ны дарга Х.Энхбаатар, ОУДБ-ын Техникийн хамтын ажиллагааны Ази, номхон далай хариуцсан захирал Ситхи Устангоу, ОУЭХАТХ-ны дарга Хэлго Удо Фокс болон Архангай, Булган, Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн, мэргэжлийн хяналтын хэлтэс, завьчид, Хөвсгөл аймгийн иргэд зэрэг 150 гаруй хүн оролцлоо. Далайн захиргаа нь Монгол Улсын томоохон гол мөрөн, нуурыг түшиглэн үйл ажиллагаа явуулж буй аялал жуучлалын байгууллага, иргэд, мэргэжлийн ажилтдад чиглэсэн сургалт, семинарыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг байна.

Энэ удаагийн семинарыг дотоодын гол мөрөн, нуур дахь тээврийн аюулгүй үйл ажиллагааг хангах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг судлах, гадаадын судлаачдын зөвлөмж, зөвлөгөөг аваад зогсохгүй орон нутаг дахь тээвэрлэлтийн нөхцөл байдлын талаар үндэсний хэмжээнд харилцан ярилцаж, туршлага судлах зорилгын хүрээнд зохион байгуулж буй аялал жуучлалын байгууллага, иргэд, мэргэжлийн ажилтдад чиглэсэн сургалт, семинарыг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг байна.

хүчин шаардлагатай. Мөн иргэдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх ч шаардлага бий. Хөвсгөл нуурыг зорьж ирж байгаа хүмүүс ихэвчлэн их усны талаар ямар ч мэдлэггүй байдаг. Зүгээр л амрах, зургаа авахуулах, зугаацан цэнгэх гэж л ирдэг. Гэтэл завь нь дээр гарах дүрэм, журам хүртэл байдаг. Энэ бүгд усан зам тээврийн аюулгүй үйл ажиллагааг хангах зорилготой. Тэр дундаа зорчигчдын амь насыг хамгаалах чухал ач холбогдолтой. Гэтэл энэ хорио цээрийг хүмүүс мэддэггүй. Хэлсэн ч тоодоггүй. Энэ байдлаас болж амиараа хохирох тохиолдол гардаг. Тиймээс усан замын тээврийн аюулгүй үйл ажиллагааны сургалтыг Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газар Далайн захиргаа, ЗТЯ-тай хамтран зохион байгуулж байна. Өнөөдөр бид бие биенээсээ харилцан туршлага солилцож, алдаа оноогоо хэлэлцэн цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох өдөр. Тиймээс та бүхэн семинартаа идэвхтэй оролцоорой” гэв. Мөн энэ үеэр Далайн захиргааны дарга Х.Энхбаатар байгууллагынхаа талаар товч танилцуулга хүргэсэн юм. Тус байгууллага нь үндэсний хөлөг онгоц, багийн гишүүдтэй болж эх орныхоо экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг далайгаар тээвэрлэх эрхэм зорилготой бөгөөд 2003 онд үйл ажиллагаагаа эхэлж байсан түүхтэй. Одоогийн байдлаар далайн тээвэрлэлт, хөлөг онгоц бүртгэл, дотоодын усан замын тээвэр, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, боомт ашиглах, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж.

Тэр дундаа далайн боомт ашиглах, хөлөг онгоцны бүртгэлийг хийж эхэлсэн гэнэ. Энэ нь Монгол Улсыг дэлхийд таниулах, нэр хүндийг нь өсгөх төдийгүй цаашид дотоодын бараа бүтээгдэхүүнийг олон улсад тээвэрлэх суурь болж байгаа юм. Тухайлбал, Сингапур улсад үйл ажиллагаа явуулдаг “Монголын хөлөг онгоцны бүртгэл” хамтарсан компанид 2003-2015 онд давхарсан тоогоор гадаадын 2800 гаруй хөлөг онгоц бүртгүүлэн аялжээ. Харин одоогийн байдлаар 30 орны эзэмшил бүхий 500 гаруй хөлөг онгоц манай улсын далбаан дор эх далайд аялдаг байна. Дээрх хөлөг онгоцнуудын бүртгэлийн хураамжаас олсон нийт ашгаас жилд 3.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт суулгажээ. Мөн дотоодын онгоцны бүртгэлийг ч гүйцэтгэдэг. Түүнчлэн тус байгууллага дотоодын усан замын тээвэрлэлтийн хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хяналт зохицуулалтын системийг тодорхой болгох зорилгын хүрээнд “Усан замын тээврийн тухай” бусад дүрэм журмыг хэрэгжүүлж ажиллажээ. Тэр дундаа усан замын тээврийн аюулгүй үйл ажиллагаа, зорчигчдын аюулгүй байдлыг хангахын тулд 2014 онд “Аврах хантаазны Олон улсын ISO 12402” стандартыг Монгол Улсын болгож батлуулсан хэмээн Далайн захиргааны дарга Х.Энхбаатар хэлсэн юм. Жилээс жилд Хөвсгөл нуурыг зорих иргэдийн тоо ихэсхийн хэрээр ослын хэмжээ ч нэмэгджээ. Тус нууранд жилд дунджаар долоон хүн нас бардаг тухай Хөвсгөл аймгийн онцгой газрын албаныхан хэлж байв. Осол гарч буй шалтгаан нь иргэд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ нууранд орох, хэт олуулаа нэг завинд суух, аврах хантааз хэрэглэдэггүйгээс болдог байна. Тодруулбал, өнгөрсөн зургадугаар сард согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ нуур луу машинтайгаа орсон, мөн дөрвөн хүн тээвэрлэсэн моторт завь хөмөрсөн зэрэг хэрэг гарчээ. Хөвсгөл нуурт одоогийн байдлаар нэг ачаа ачигч Сүхбаатар онгоц болон 80 гаруй моторт завь иргэдийг тээвэрлэдэг ажээ. Улмаар лект семинарт оролцогчдын илтгэл зөвлөгөөнөөр үргэлжилж, ОУЭХАТХ-ны дарга Хэлго Удо Фокс манай улсын эрэл, хайгуулын үйл ажиллагаанд зориулж нэгдсэн зөвлөмжийг хүргэсэн. Тэрбээр, “Монгол Улсын хувьд эрэл, хайгуулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хийх хэрэгтэй. Мөн хөлөг онгоцны багийнхан нуурт гарахаасаа өмнө нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж байх шаардлагатай” гэдгийг онцоллоо. Харин зөвлөгөөний хоёр дахь өдөр завьчдад зориулсан тусгай сургалтыг

явуулсан юм. Энэ үеэр гадаад болон дотоодын мэргэжилтнүүдтэй уулзаж, ярилцав.

Хэлго Удо Фокс: Аюултай завь хүн тээвэрлэхийг төрөөс зөвшөөрч огт болохгүй

/ОУЭХАТХ-ны дарга/

“Монголын эрэл хайгуул, аврах ажиллагааны талаар судалсан гэсэн. Энд ихэвчлэн мэргэжлийн бус хувиараа бизнес эрхэлж байгаа хүмүүс завь жолооддог. Гэтэл эдгээр хүмүүс хамгийн түрүүнд зорчигчдод тусламж үзүүлэх хүний тоонд ордог. Эдгээр хүмүүс юуг анхаарах хэрэгтэй вэ. Одоо бол ямар аюул тохиолдоход юу ч хийж чадахгүй л нөхцөлд байна шүү дээ?”

“Энд үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс бэлэн биш байна. Ямар нэгэн осол гарлаа бэлэн биш. Огт бэлтгэлгүй. Ямар ч зүйл болохгүй юм шиг л явж байгаа. Жуулчдын тоо улам нэмэгдэнэ. Тэгэхээр ямар нэгэн осол гарлаа гэхэд аймшигтай зүйл болох нь тод харагдаж байна. Тиймээс зайлшгүй нэг төлөвлөгөө байх ёстой. Тэр төлөвлөгөөний дагуу өөрсөдөө байгаа нөөц болоцоог ашиглан боломжтой бүх арга хэмжээг урьдчилж авсан байх ёстой. Мөн осол болсон тохиолдолд юу хийх вэ гэдгээ мэддэг байх хэрэгтэй. Өөрийн гэсэн төлөвлөгөө чухал.

“30 жилийн түүхтэй Сүхбаатар онгоцны талаар сонссон байх. Энэ онгоц өөрөө 150 хүн зөөх боломжтой. Гэтэл одоо 200 зарим тохиолдолд 250 хүн ч тээвэрлэж байна. Хөлөг онгоцны насжилт хэр урт байдаг юм бэ. Энэ онгоц тээвэрлэлт хийж болох уу?”

“Хөлөг онгоцны нас нэг их чухал биш байдаг. Тухайлбал, агаарын тээврийн хэрэгсэл ямар нэгэн зүйл нь эвдэвэл засварладаг. Үүнтэй адил арчлагт, хамгаалалт их чухал. Тэгэхээр хөлөг онгоцны насжилт чухал биш. Харин юу асуудал вэ гэхээр энэ хугацаанд ямар засвар хийсэн, хаана хийсэн бэ гэдэг чухал. Зэвэрсэн хэсэг байх юм бол тэр хэсгийг аваад оронд нь эзвэрлэх бөх бат чанартай гагнаад хийсэн бол асуудал биш. Хамгийн гол нь ийм үйлчилгээ хийгдсэн үү, үгүй юу гэдэг нь асуудал. Зарим тохиолдолд тоног төхөөрөмж нь эвдэвэл түүнийг солих ёстой. Гэтэл тэр төхөөрөмж нь монголд байхгүй байна гэж болдөг. Хэрвээ тэгвэл тэр хэмжээгээр энэ хөлөг онгоцны аюулгүй байдал улам л муудна гэсэн үг. Тухайлбал, 150 хүнийг тээвэрлэж байна гэж болдөг. Гэтэл тэр хүмүүсийг тээвэрлэж байхад ямар нэгэн осол боллоо гэхэд энэ тохиолдолд хөлгийн баг юу хийх ёстойгоо мэдэж байгаа юу, хөлөг онгоцон дээр 150 хүнийг аврах хантааз, цагираг хүрэлцээтэй байгаа юу гэдэг мөн л асуудал. Түүнчлэн хөлөг онгоц сүйрэхэд онгоцны багийнхан аргаллаа гэж бодоход тэдэнд хэн ирж туслах вэ, тэр хүн тодорхой юу, үгүй юу гэдгийг бодох л хэрэгтэй. Бас нэг жишээ дурьдаа. 20 хүнийг уснаас гаргалаа гэж бодоход зарим хүмүүс нь осгосон байвал яах вэ. Яаж тэр хэнийг хэвийн болгох, тэр хүнд үйлчилгээ үзүүлж чадах хүн байна уу. Зарим хүмүүс хэт даарснаас болоод шууд зурх нь зогсдог. Тэр үед ямар арга хэмжээ авахыг мэддэг хүн байна уу. Хэрвээ тийм зүйл байхгүй, мэдэхгүй гэвэл дотроосоо дулаан ялгаруулдаг хантааз байгаа юу. 150 хүний хантааз онгоцон дээр бэлэн л байх ёстой. Тэгэхээр сая миний хэлсэн зүйлс SOLOS буюу Монгол Улсын нэгдэн орсон “Далай дахь хүний аюулгүй байдал” конвенцийн шаардлага юм. Тиймээс Сүхбаатар онгоцондоо SOLOS конвенцийнхоо шаардлагыг тавиад үзээч ээ гэдэг зөвлөгөөг л өгмөөр байна.

“Хөвсгөл нуурт завь ажиллуулж байгаа хүмүүс амьдрахын эрхэнд мөнгө олохын тулд ингээд яваад л байна. Шууд боль гэж тулгах боломжгүй. Олон улсын жишээгээр энэ байдлыг хэрхэн зохицуулсан байдаг вэ. Төрийн зүгээс ямар ажил хийвэл үүнийг зохицуулж болох вэ?”

“Нэгдүгээрт, хууль тогтоомж хэрэгтэй. Яг юу болох юм, юу болохгүй юм гэдгийг тодорхой заагаад өгсөн байх ёстой. Тухайлбал, 60 хүнтэй

автобустай явж байлаа гэж болдөг. Гэтэл тэр автобусны тормос нь эвдэрсэн байвал та нар явж чадах уу. Тэгэхээр автобусан дээр гэхэд аюулгүй байдал нь тодорхой байгаа шүү дээ. Бүгдийг нь тодорхой заасан байгаа. Шөнийн гэрэл нь байхгүй байвал явуулахгүй торгодог биз дээ. Яг түүнтэй адил. Бүр тодруулбал, зөвхөн өдөр явна. Орой явж болохгүй гэдэг ч юм уу. Маш тодорхой журмыг л тогтоогоод өгчих хэрэгтэй. Тэдэн хүн, тим цагт л авч явна гэх мэтчилэн. Эдгээр зүйлс хууль эрхзүйн хувьд маш ойлгомжтой, тодорхой байх ёстой. Хүний амь нас үрэгдэнэ гэдгийг мэдсээр байж мөнгө олохоор явна гэдэг бол байж болохгүй. Хэзээ ч төрөөс зөвшөөрөхгүй ёсгүй зүйл.

Ситхи Устангоу: Монголд сургалтын болон техникийн туслаацаа үзүүлэхэд бэлэн

/ОУДБ-ын Техникийн хамтын ажиллагааны Ази, номхон далай хариуцсан захирал/

“Олон улсын далайн байгууллага болон Олон улсын далайн эрэн хайх, авран туслах байгууллага монголд ирсэн учир нь гэвэл Монгол Улсын ЗТЯ, далайн захиргаа хүсэлт тавьсан. Хэдийгээр далайд гарцгүй улс орон хэдий ч эдгээр байгууллагууд дотоодын усан замын тээврийн аюулгүй ажиллагаанд маш их анхаарал тавьж байгаа. Аюулгүй ажиллагааг зөв хөгжүүлэх тал дээр маш их анхаардаг. Энэ асуудлыг зөвхөн танай Далайн захиргаа шийдэж чадахгүй. Үүнд оролцож байгаа бүх агентлагууд хамт шийдэх асуудал. Би Монголд сургалт зохион байгуулах, техникийн асуудал дутагдалтай юм байна гэдгийг олж харлаа. Үүнийг өөрийн байгууллагадаа хүргэнэ. Дээрх хоёр асуудалд дэмжиж ажиллах шаардлагатай гэдгийг уламжилна. Ингэсний дараа бид санал солилцож, эргээд Монгол улсын засгийн газарт хандана. Хэдийгээр бидэнд техникийн тал дээр бага хэмжээний санхүүжилт байдаг ч тодорхой хэмжээг Монгол Улсад зориулах болно. Ер нь улс бүр өөр өөрийн онцлогтой. Хөвсгөлийн хувьд нэг талд Засгийн газраас барьж байгаа хяналтын бодлого нөгөө талд иргэдийн мөнгө олох гэсэн хүсэл тэмүүлэл байна. Тэгэхээр цэнгэг усны нөөцийг мөнгө олох зориулалтаар бүрэн ашиглуулах асуудал байж болохгүй. Хоорондоо уялдаа холбоотой байгууллагууд нийлж нэгдсэн нэг шийдвэр гаргах хэрэгтэй. Мэдээж, гаргасан шийдвэр хүн болгонд таалагдах албагүй. Тухайлбал, энэ нууранд зөвхөн нарны эрчим хүчээр ажилладаг завь явж болно. Шатахуун ашигладаг завь явуулахгүй гэсэн туршлага зарим улсад байдаг. Тэгэхээр олон арга байж болохын нэг жишээ нь энэ. Ер нь энэ асуудлыг та бүхэн дотооддоо шийдэх ёстой. Харин бид Монгол Улс ийм шийдвэр гаргаж байна гэхэд сургалтын болон техникийн тусламж үзүүлэхэд бэлэн байна.

А.Даваабаяр: Цэнгэг усны зориулалтын бус завь Хөвсгөл нуурт явж байна

/Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга/

“Хөвсгөл нуурт явж байгаа зарим завьнууд цэнгэг устай нууранд явахад тохиромжгүй байдаг. Учир нь өндөр хөгжилтэй оронд цэнгэг устай нууранд усан дээрээ цэнгэлдэг завь хэрэглэхийг хориглодог. Газар дээр банкаа цэнгэлддэг. Харин цэнгэлдсэн банкаа ганцхан хоолойгоор дамжуулж шатахуунаа хийдэг засгийг зөвшөөрдөг. Гэтэл манай улсад нуурын усан дээрээ онгоцныхоо банкыг цэнгэлддэг. Тэгэхээр цэнгэлдэж байх явцад усанд шатахуун асгарах аюултай. Асгарч л байгаа. Мөн анхаарал, болгоомж муутай хүн онгоцны хажууд тамхи татаж байгаад гал гаргах ч эрсдэлтэй. Хэрвээ тэгвэл тэр онгоцон дээр байгаа бүх л хүн аюулд орно. Тиймээс цаашид завь үйлчилгээ явуулж буй хүмүүс үүнийг анхаарах хэрэгтэй. Энэ бол усан тээврийн аюулгүй ажиллагааг хангахад чиглэсэн чухал ажлын нэг юм.

ШУУРХАЙ МЭДЭЭ

Үндэсний их баяр НААДМЫН ХӨТӨЛБӨР

ТУЛГАР ТӨРИЙН 2225, ИХ МОНГОЛ УЛСЫН 810, АРДЫН ХУВЬСГАЛЫН 95 ЖИЛИЙН ОЙ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ХӨТӨЛБӨР

7 дугаар сарын 7. Пүрэв

9:00-19:00 Урианхай сурын харваа Сурын талбайд

7 дугаар сарын 8. Баасан

9:00-18:00 Буриад сурын харваа Сурын талбайд

7 дугаар сарын 9. Бямба

9:00-19:00 Хүүхдийн сурын харваа Сурын талбайд

7 дугаар сарын 10. Ням

8:00-11:00	Хязаалан насны морьдын уралдаан	Хүй долоон худагт
08:00	Шагайн харвааны хэсгийн харваа	Шагайн асарт
10:30	Үндэсний сурын хана харвааны эхэн өрөг	Сурын талбайд
10:00-11:00	Төрийн далбааны одорт зориулсан хүндэтгэлийн ёслол	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
12:00-12:30	Жанжин Д.Сүхбаатарын хөшөөнд цэцэг өргөх, Их эзэн Чингис хааны хөшөөнд хүндэтгэл үзүүлэх ёслол	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
14:00-16:20	Шүдлэн насны морьдын уралдаан	Хүй долоон худагт
14:30-18:30	Үндэсний сурын хана харвааны дунд өрөг	Сурын талбайд
14:00-18:00	Тулгар төрийн 2225, Их Монгол улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын Төрийн хүндэтгэлийн концерт	Нийслэлийн Соёлын төв өргөөнд
16:00	Дээлтэй монгол наадам	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
20:00	Монгол Улсын Төрийн тугийг цэнгүүлэх ёслол	Төрийн ордон, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
22:00	"Учиртай гурван толгой" дуурь	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд

7 дугаар сарын 11. Даваа

08:00-11:40	Азарганы уралдаан	Хүй долоон худагт
9:30	Монгол Улсын Төрийн тугийг Төрийн ордоос Төв цэнгэлдэх хүрээлэн рүү залах ёслол. /тусгай хөтөлбөрөөр/	
10:00	Шагайн харвааны хагас шигшээ харваа	Шагайн асарт
11:00	Монгол Улсын Төрийн тугийг Төв цэнгэлдэх хүрээлэнд залах ёслолын ажиллагаа	
11:10	Тулгар төрийн 2225, Их монгол улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж нээж, Монгол Улсын төрийн туганд хүндэтгэл үзүүлэнэ	Төв цэнгэлдэх хүрээлэнд
11:20	Үндэсний их баяр наадмын нээлтийн ажиллагаа /тусгай хөтөлбөрөөр/	
11:30	Шагайн харвааны тэмцээний нээлтийн ажиллагаа	Шагайн асарт
12:00-16:10	Хүчигт бөхийн барилдааны нэгийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
12:30	Шагайн харвааны хагас шигшээ харваа	Шагайн асарт
13:30-14:00	Үндэсний сурын нэгдсэн үзүүлэх харваа	Сурын талбайд
13:30-16:00	Хүүхдийн барилдааны нэгийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
14:00	Хүй долоон худагийн наадмын нээлтийн ажиллагаа /тусгай хөтөлбөрөөр/	Хүй долоон худагт
14:00-17:00	Их насны морьдын уралдаан	Хүй долоон худагт
14:30-16:30	Үндэсний сурын хана харвааны адаг өрөг	Сурын талбайд
16:20-18:00	Хүүхдийн барилдааны хоёрын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
16:20-19:30	Хүчигт бөхийн барилдааны хоёрын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
16:30-20:00	Үндэсний сурын хасаа харвааны эхэн өрөг	Сурын талбайд
20:00-20:30	Улаанбаатарын үдэш "Эх орноо магтан дуулья" урлагийн тоглолт	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
23:00	Баяр наадмын ёслолын буудлага	Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд

7 дугаар сарын 12. Мягмар

07:00-09:20	Соёлон насны морьдын уралдаан	Хүй долоон худагт
8:00	Шагайн харвааны шигшээ харваа	Шагайн асарт
08:00-12:00	Үндэсний сурын хасаа харвааны дунд өрөг	Сурын талбайд
09:00-11:40	Хүчигт бөхийн барилдааны гурвын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
10:00-11:00	Хүүхдийн барилдааны гурвын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
10:30-12:30	Дааганы уралдаан	Хүй долоон худагт
11:20-12:40	Хүүхдийн барилдааны дөрвийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
11:50-13:30	Хүчигт бөхийн барилдааны дөрвийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
12:00-13:40	Үндэсний сурын хасаа харвааны адаг өрөг	Сурын талбайд
12:30	Шагайн харвааны харваачдад шагнал гардуулах ёслол	Шагайн асарт
13:40-14:00	Үндэсний сурын түрүү тодруулах шилдэг 8 харваачийн харваа	Сурын талбайд
14:30-15:50	Хүчигт бөхийн барилдааны тавын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
15:20-16:00	Хүүхдийн барилдааны тавын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
15:50-16:00	Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж үндэсний сур, шагайн харваанд түрүүлсэн харваачдад шагнал гардуулна. Улсын цолны болзол хангасан сурын харваачдад цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

16:00-17:20	Хүчигт бөхийн барилдааны зургаагийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
16:40-17:10	Хүүхдийн барилдааны зургаагийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
17:20-17:50	Турүүлж, айрагдсан морьдын цол дуудаж, уяачдад шагнал гардуулна. Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж хурдан морь унаач хүүхдүүдэд бэлэг гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд
17:50-18:50	Хүчигт бөхийн барилдааны долоогийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
18:30-19:00	Хүүхдийн барилдааны долоогийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
18:50-19:10	Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж "Улсын начин", "Улсын харцага" цолны болзол хангасан бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд
19:10-20:00	Хүчигт бөхийн барилдааны наймын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
20:00-20:10	Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж "Улсын заан" цолны болзол хангасан бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд
20:10-20:50	Хүчигт бөхийн барилдааны есийн даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
20:50-21:00	Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж 9 давсан бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд
21:00-21:30	Хүчигт бөхийн барилдааны аравын даваа	Төв цэнгэлдэх хүрээлэнд
21:30-21:45	Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж Үндэсний их баяр наадмын хүчигт бөхийн барилдаанд түрүүлж, үзүүлсэн бөхчүүдэд цол олгож, үнэмлэх, энгэрийн тэмдэг, шагнал гардуулна	Төв цэнгэлдэх хүрээлэнд
21:45	Тулгар төрийн 2225, Их монгол улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ой, Үндэсний их баяр наадмын ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж хаана	
21:50	Үндэсний их баяр наадмын хаалтны ажиллагаа, Монгол Улсын төрийн тугийг Төв цэнгэлдэх хүрээлэнгээс Төрийн ордон руу залах ёслол. /тусгай хөтөлбөрөөр/	

7 дугаар сарын 13. Лхагва. УЯАЧДЫН НААДМЫН ХӨТӨЛБӨР

07:00-09:20	Эрлийз хурдан морьдын дээд нас буюу азарга, их нас, соёлон морьдын уралдаан	Хүй долоон худагт
10:30-12:30	Эрлийз хурдан морьдын дунд нас буюу шүдлэн, хязаалан морьдын уралдаан	
13:00-13:05	Монгол Улсын Шадр сайд, Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны дарга Ц.Оюунбаатар уяачдын наадмыг нээж	
10:00-15:00	Жороо морьны тойргийн уралдаан	
13:05-13:20	Уяачдын наадмын нээлтэнд зориулсан урлагийн тоглолт /тусгай хөтөлбөрөөр/	
13:20-14:20	Хүчигт бөхийн барилдааны нэгийн даваа	

14:20-14:30	Үндэсний их баяр наадамд түрүүлсэн, үзүүлсэн, шөвгөрсөн бөхчүүдэд бай шагнал, цолны чимэг хүртсэн бөхчүүдэд үнэмлэх гардуулна	
14:00-16:00	Эрлийз хурдан морьдын бага нас буюу дааганы уралдаан	
14:30-15:20	Хүчигт бөхийн барилдааны хоёрын даваа	
15:20-15:30	Урлагийн тоглолт	
15:30-16:30	Хүчигт бөхийн барилдааны гурав, дөрвийн даваа	
16:30-16:40	Урлагийн тоглолт	
16:40-17:00	Хүчигт бөхийн барилдааны тавын даваа	
17:00-17:30	Турүүлж, айрагдсан морьдын цол дуудаж, шагнал гардуулна	
17:00-17:50	Хүчигт бөхийн барилдааны зургаагийн даваа	
17:50-18:20	Хүчигт бөхийн барилдааны долоогийн даваа	
18:20-18:40	Хүчигт бөхийн барилдаанд түрүүлсэн, үзүүлсэн, шөвгөрсөн бөхчүүдэд шагнал гардуулна	
18:40	Хурдан морьны салбар хорооны дарга Б.Батсайхан уяачдын наадмыг хаана	

ТУЛГАР ТӨРИЙН 2225, ИХ МОНГОЛ УЛСЫН 810, АРДЫН ХУВЬСГАЛЫН 95 ЖИЛИЙН ОЙ, ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН СОЁЛ УРЛАГИЙН ҮЗЭВЭР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд
 07 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд: 10:00-20:00 "Дэлхийн соёлын монгол өв" урлагийн тоглолт, үзэсгэлэн
 07 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд: 10:00-20:00 "Монголын гайхамшигт урлаг" ардын урлагийн тайлбарт тоглолт

Хүй долоон худаг
 07 дугаар сарын 11-нд: 16:00-19:00 "Холч морьдын уралдаан"
 07 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд: 10:00-18:00 "Сэрсэн тал" Соёлын наадам /тусгай хөтөлбөрөөр/
 07 дугаар сарын 11-нд: 14:50-15:20 "Морьтон Монголчууд" морин спортын үзүүлэх тоглолт, цирк болон сонгомол морьдын үзүүлбэр
 07 дугаар сарын 11-нд: 14:00 "Хүй долоон худагийн наадмын нээлтийн ажиллагаа"
 07 дугаар сарын 12-нд: 07:50-08:20 "Морьтон Монголчууд" морин спортын үзүүлэх тоглолт, цирк болон сонгомол морьдын үзүүлбэр
 07 дугаар сарын 13-нд: 11:40-12:10 "Морьтон Монголчууд" морин спортын үзүүлэх тоглолт, цирк болон сонгомол морьдын үзүүлбэр
 07 дугаар сарын 13-нд: 07:00-18:40 "Уяачдын наадам" /тусгай хөтөлбөрөөр/

Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд
 07 дугаар сарын 10-нд: 16:00 "Дээлтэй монгол" наадам
 07 дугаар сарын 10-нд: 22:00 Б.Дамдинсүрэн "Учиртай гурван толгой" дуурь
 07 дугаар сарын 11-нд: 21:00 "Улаанбаатарын үдэш-Эх орноо магтан дуулья" Харанга хамтлагийн тоглолт
 07 дугаар сарын 12-нд: 21:00 "Талын бүжин" Монгол туургатны бүжгийн наадам- Монгол дэнс фестиваль
 07 дугаар сарын 13-нд: 21:00 "Морин хуур" Олон улсын фестиваль
 07 дугаар сарын 14-нд: 21:00 "Ulaanbaatar swing night" их талын жазз олон улсын фестиваль

МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн Засаг дарга Су.Батболд ажлаа хүлээн авлаа

ЖОТГОН

НИТХ-ын анхдугаар хуралдаанаас Нийслэлийн Засаг даргад С.Батболдын нэрийг нь дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдад батламжлуулахаар өргөн барьсан билээ. Тэгвэл Ерөнхий сайд захирамжаа гаргаж, С.Батболдыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар томилсон байна. Тиймээс нийслэлийн Засаг даргаар томилогдсон С.Батболд өчигдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүрэлцэн ирж, Тамгын газрын хамт олны өмнө Улаанбаатар хотын 31 дэх даргаар дөрвөн жил ажилласан Э.Бат-Үүлээс тамгаа гардаж авлаа. Энэ үеэр Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт танилцуулсан бөгөөд Э.Бат-Үүл нийслэлийн төсвийн өнөөгийн байдлын мэдээ болон өнөө жил нийслэлд өрнөж буй бүтээн байгуулалт,



Гэрэл зурагч Г.АРГУУЖИН

цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар мэдээлэл өглөө. Тэрбээр "Дарга нарын эрх мэдэл, үзэгний үзүүрт байсан төрийн үйлчилгээг бид нэг цэгт төвлөрүүлсэн нь нийслэлийн иргэдийн хамгийн их талархал хүлээн авсан ажил болсон. Тиймээс Нийслэлийн

Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлж, улам боловсронгуй болгоход анхаарч ажиллаарай" гэсэн юм. Мөн гэр хорооллын дахин төлөвлөлт, "Сайн хашаа" хөтөлбөр, "Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийг үргэлжлүүлэхийг

хүсээд, НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нийт албан хаагчдад баяр хүргэж, талархал илэрхийллээ. Харин нийслэлийн Засаг даргын үүрэгт ажлаа хүлээн авсан С.Батболд, "Төрийн алба бол тасралтгүй үргэлжлэх ёстой. Та бидний

өмнө Үндэсний их баяр наадам, АСЕМ-ын дээд хэмжээний уулзалтуудыг зохион байгуулах гэх мэт томоохон ажлууд хүлээж байна. Тиймээс төрийн албыг нэг хором ч тасалдуулагүйгээр цааш үргэлжлүүлэн явуулахыг та бүхнээс хүсч байна. Монгол төрийн өлмий баг оршиж, Нийслэл Улаанбаатар хот маань Нийслэл Улаанбаатар хот маань нийслэл Улаанбаатар хот маань гэсэн юм. Нийслэлийн Засаг дарга асан Э.Бат-Үүл ажлаа хүлээлгэн талархалыг хамгийн ихээр хүлээгээд байгаа ажлын нэг болох Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийг шинэ Засаг даргад танилцууллаа. Энэ үеэр тэрбээр "Төрийн үйлчилгээг авахад иргэдэд хамгийн их дарамт учруулдаг зүйл бол дарга нарын хүнд суртал байдаг. Тийм учраас дарга нараас хамааралгүйгээр иргэд төрийн үйлчилгээг авдаг зарчим руу шилжиж, иргэддээ үйлчилдэг байх гэж шийдэж

нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийг гурван газар байгуулсан. Одоо иргэд төрийн үйлчилгээг ямар ч дарга нарын гар харалгүй, төвөггүй, бэрхшээлгүй супермаркетаас бараа авч байгаа шиг л авдаг болсон. Ингэснээр бид дарга нарын хүнд суртлыг арилгах тогтолцоог бий болгож чадсан юм" гэлээ. Дашрамд дуулгахад, Иргэдэд төрийн үйлчилгээг "Хурдан, Тэгш, Нээлттэй" үзүүлэх зорилгоор Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн "Дунжингарав" салбарын үйл ажиллагааг өнгөрсөн нэгдүгээр сарын 04-нөөс, "Мишээл" салбарын үйл ажиллагааг дөрөвдүгээр сарын 18-наас, "Драгон" салбарын үйл ажиллагааг дөрөвдүгээр сарын 23-наас эхлүүлсэн билээ. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс Засгийн газрын зарим яам, агентлагын 99 үйлчилгээ, нийслэлийн 27 байгууллагын 287, нийт 386 нэр төрийн үйлчилгээг өдөр тутамд үзүүлж байгаа юм.

ЗАВСАРЛАГА

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

ТҮРҮҮ БӨХИЙГ ШИНЭ ЗАГВАРЫН ЛАНД
200 МАШИНААР ШАГНАНА

Б.ДАВААХҮҮ

Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хорооны ажлын хэсгийн дарга М.Отгонбаяраас зарим зүйлийг тодрууллаа.

“Тоёота мотор” корпораци энэ жилийн наадмын турру бөхөд Ланд 200 маркийн машин бэлэглэнэ гэсэн. Энэ талаар тодруулахгүй юу?

Тоёота мотор корпораци Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хороотой хамтарч, албан ёсны түншээр нь ажилладаг. Энэ хүрээнд улсын наадмын үндэсний бөхийн барилдаанд уран мэхээ уралдуулан барилдаж, түрүүлсэн бөхийг тус корпораци Ланд 200 маркийн машинаар шагнадаг уламжлал тогтоод эдүгээ гурав дахь жилтэйгээ золгож байна. Энэ жил ч гэсэн 2016 оны шинэ загварын Ланд 200 машинаар түрүүлсэн бөхийг шагнаж урамшуулна. Ерөнхийдөө энэ сарын 13-нд 10:30 цагаас тулгар төр байгуулагдсаны 2225, их Монгол улс байгуулагдсаны 810, ардын хувьсгалын 95 жилийн ойн баярын үндэсний бөхийн барилдаанд түрүүлсэн түрүү бөхөд шагналыг нь гардуулах үйл ажиллагаа болно.

Чингисийн талбайд Тоёота корпораци тусгайлан тайззассан байгаа харгадсан. Энэ ямар учиртай юм бол?

Чингисийн талбайд Тоёота корпорацийн мэдээллийн төв ажиллаж байгаа. Долдугаар сарын 14-нийг

дуустал нийслэлчүүд Монгол дахь Тоёота корпорацийн төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа хийгээд шинэ загварын Тоёота маркийн автомашинуудтай танилцаж, үзэж сонирхох боломжтой.

Тоёота корпораци түрүү бөхийг Ланд Крузер машинаар шагнаж юм байна. Улсаас яаж урамшуулах вэ?

Баяр наадмын түрүү бөхийн бай шагнал Засгийн газрын тогтоолоор батлагдсан байдаг. Үндэсний бөхийн барилдаанд түрүүлсэн бөх 15 сая төгрөгийн бай авдаг юм. Үүн дээрээ нэмээд Ланд 200 машинтай болно гэсэн үг. Харин үзүүлсэн бөхийг 10 сая төгрөгөөр байлдаж.

Зөвхөн үндэсний бөхийн барилдаанд түрүүлсэн бөхийг л машинаар шагнана гэсэн үг үү?

Тийм ээ. Ер нь гурав дахь жилдээ түрүү бөхийг Ланд 200 машинаар шагнаж гэж байна. Үндэсний бөхийн барилдаанд түрүүлсэн бөхөд л очно.

Тусгайлан тайз засч, урлаг соёлын үйл ажиллагааг зохион байгуулна гэж тус корпорацийн Монгол дахь төлөөлөгчийн газрын захирал ярьсан байсан. Энэ талаар тодруулахгүй юу?

Одоогоор Чингисийн талбайд тусгай тайз засч, тэндээ түрүү бөхөд очих машиныг байрлуулчихсан байгаа. Тус тайз дээрх лед дэлгэцээр Үндэсний баяр наадмыг шууд дамжуулна. Мөн наадамчин олонд зориулсан урлаг уран сайхны тоглолт зохион байгуулагдах юм.

Энэ жил 1024 хүчит бөх хурд хүчээ сорино. Онцлог



нь юу байх вэ?

Энэ жилийн хувьд гурван тэгш ой тохиосон баяр наадам болж байгаа. 1024 бөх барилдах бөгөөд 10 даваатай байна. Хамгийн гол онцлог нь энэ. Бөхийн барилдаан сайхан болох байх аа. Улсын цолд хүрэх зорилго тавьсан шинэ залуу бөхчүүд бэлтгэлдээ гарчихсан байгаа. Тэд маань сайн барилдаж, үзэгч олноо баясах байх.

АСЕМ-тай холбогдуулан сум, аймгийн наадам Үндэсний баяр наадмын барилддаг бүхий л бөхчүүд улсын наадамд зодоглохоор бэлтгэлээ базааж буй байх. Бөхийн барилдаанд оролцох бөхчүүдийг бүртгэхдээ шалгуур тавьж байгаа юу?

Үндэсний бөхийн салбар

хороо долдугаар сарын 9-нөөс бөхийн барилдаанд оролцох бөхчүүдээ бүртгэж эхлэх юм билээ. Шалгуур харьцангуй гайгүй байх болов уу. АСЕМ-ыг зохион байгуулж байгаатай холбоотойгоор аймгийн наадмуудыг долдугаар сарын 15-25-ны хооронд зохион байгуулахаар тогтоосон. Наадам давхцахгүй болохоор Үндэсний баяр наадамдаа залуу бөхчүүд түлхүү барилдах байх. Энэ жил 1024 бөх барилдах учир олон цолтон төрөх болов уу гэж таамаглаж байна.

Ернэнэжилийн наадмын зохион байгуулалтад хэчнээн төгрөг төсөвлөсөн бэ?

Наадмын зохион байгуулалтад хоёр тэрбум гаруй төгрөг төсөвлөсөн. Үүнээс соёл урлагийн салбарт хамгийн их буюу нэг тэрбум

орчмыг зарцуулаа. Дараагаар нь тохижилтод 600 орчим саяыг, бусад салбарт үлдэснийг зарцуулсан.

Баяр наадмын өдрүүдэд цаг агаар 30 хэм хүрнэ гэж байгаа. Энэ талд хэрхэн анхаарч байна вэ?

Төв цэнгэлдэх хүрээлэнд 18 секц байдаг. Үүний тал нь сүүдрэвчтэй. Энэ жилийн баяр наадмын өдрүүдэд цаг агаар нэлээн халах төлөвтэйг цаг уурын байгууллагаас мэдээлсэн. Тиймээс ус, ундаагаар хангахад онцгой анхаарч байгаа. Хүй долоон худагт орчны усалгааг тасралтгүй хийхээр төлөвлөсөн. Ялангуяа соёл урлагийн талбайд усалгааны системийг тавьсан. Ингэснээр иргэдэд сэрүүхэн сайхан байх болов уу гэж бодож байна.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр -9
Шөнө -1

Нөгөөдөр
Өдөр -9
Шөнө -1

Өдрийн зурхай

2016.07.07 / БИЛГИЙН
ТООЛЛЫН 3


Зуны адаг хөхөгчин хонь
сарын Найман цагаан
мэнгэтэй цагаан бар өдөр



Аргын тооллын 7 сарын 7, Бархасвадь гараг. Билгийн тооллын 3, Үнэг одтой, цагаан бар өдөр. Өдрийн наран 5 цаг 03 минутад ландан, 20 цаг 47 минутад жаргана. Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл луутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба сан тавиулах, угаал үйлдэх, альгуулах, оёлогийн түлээг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, тангарага буцаахад сайн. Золиг гаргах, болтын үйл, сэтгэлд сэтгэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод баруун ураги мөрөө гаргавал зохистой. Бага халуун болох улирал 00 цаг 30 минутад эхлэнэ. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

ТЭНГИС
КИНОТЕАТР

Хүний амьдралын түүх бол зөвхөн хайрын түүх юм. Үзэсгэлэн төгс Үүлэнсолонго, баян эцгийн өв залгамжлагч Уран, бүгдийг зохицуулагч Содоо, нууцлаг бүсгүй Анна нарыг нэгтгэсэн зүйл нь юу вэ? Хайр хүний сэтгэлийн өөрчлөн эзэмдэг шигээ амьдрал хувь тавилан, нөхөрлөл, ирээдүйг ч бас өөрчлөж чаддаг. Бүгдийг гайхшруулах нэгэн ээдрээт тавилан, сэтгэл хөдөлгөм бодит түүхээс сэдэвлэсэн “Хөөрхөн шулам” кино таны хайрын тухай ойлголтыг өөрчлөх болно. Шулам төрдөггүй, шулмыг гарцаагүй амьдралын шаардлага бий болгодог юм.



Жилд нэг удаа 12 цагийн турш аллагын гэмт хэргийг зөвшөөрдөг Цэвэрлэгээний хуультай байна. Өмнө нь цагдаагийн дэслэгч байсан Барнес хүүгээ алсан хүмүүсийн алахгүй өршөөхөөр шийднэ. Хоёр жилийн дараа ерөнхийлөгчийн сонгуулийн гол өрсөлдөгч, Цэвэрлэгээний хуулийг эцэслэхээр сонгуулийн мөрийн хөтөлбөрөө болгосон Сенатын гишүүн Чарлин Роаны хамгаалалтыг албыг ахална.



Тусгаар тогтнолын өдрөөр харь гаригийнхан дайрснаас хойш хүн төрөлхтөн тэдний технологийг ашиглан шинэ хамгаалалтын системтэй болно. Гэвч өмнөхөөсөө илүү хүчтэй дайралт ирлээ. Бидний хамгаалалт найдвартай байж чадах болов уу.

ТУН УДАХГҮЙ “ТЭНГИС”-ИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарах хугацаа 2016.07.08



Гарах хугацаа 2016.07.22



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.08.05